

ХУРААНГУЙ

ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛ 2011

Тогтвортой хөгжил болон эрх тэгш байдлыг хүний хөгжилтэй хослуулах нь: Бүх нийтийн сайн сайхан ирээдүй



Нэгдсэн
Үндэстний
Байгууллагын
Хөгжлийн
Хөтөлбөр
(НҮБХХ)

Өмнөх үг

Эх дэлхийн ирээдүй хойч үеийнхний эрүүл саруул, аз жаргалтай амьдрах эрхийг хэрхэн баталгаажуулах талаар санал бодлоо солилцож нийтээрээ даган мөрдөх нэгдмэл санаанд хүрэхээр 2012 оны 6 дугаар сард улс орны тэргүүнүүд Рио Де Жанейро хотноо чуулах гэж байна. Дэлхийн улс орнууд нэг санаа нэгдмэл хүчээр хамтарч ажиллах нь 21-р зууны хөгжлийн хамгийн чухал хөшүүрэг билээ. Дэлхийн Хүний Хөгжлийн ээлжит илтгэл болох 2011 оны энэ хэвлэл нь дээр дурьдсан чухал сэдвээр улс орнууд санал бодлоо солилцон зөвшилцөх явдлыг урагшлуулан эрчимжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулах болно.

Тус илтгэлд тогтвортой хөгжил нь шударга ёс, нийгмийн эрх тэгш байдал, сайн сайхан амьдрах бололцоог бүх нийтэд хүртээх зэрэг тэгш байдлын үндсэн асуудалтай салшгүй холбоотой хэмээх санааг тусгасан байна. Илтгэлд тогтвортой хөгжлийг цааш нь дэлгэрүүлж тайлбарлахдаа энэ нь байгаль орчны асуудлаар хязгаарлагдах ойлголт бус, харин бидний хийж буй алхам болгон өдгөө долоон тэрбум болж нэмэгдээд байгаа дэлхийн нийт хүн ам, улам өсөн нэмэгдсээр байх ирээдүйн хүн амд шууд нөлөө үзүүлнэ гэдгийг ухамсарласны үндсэн дээр, амьдрах, оршин тогтнох хэв маягаа хэрхэн сонгох асуудлыг хамарсан маш өргөн хүрээний ойлголт гэж дурьджээ.

Хэрэв бид өнөөгийн болон ирээдүй үеийнхний хүний эрхийг нэмэгдүүлэхэд зорьж буй бол тогтвортой хөгжил болон эрх тэгш байдлын хоорондын уялдааны талаар зөв ойлголттой болох нь нэн чухал. Сүүлийн хэдэн арван жил дараалан хүний хөгжилд гайхамшигтай дэвшил гарч буйг дэлхийн хүний хөгжлийн илтгэлүүдэд тэмдэглэж байна. Улс орнууд хүрээлэн буй орчин болон эрх тэгш байдалд аюул учруулж буй эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн зоримог алхам хийхгүй бол эдгээр ахиц дэвшлийн үр дүнг удаан хадгалж чадахгүйд хүрч байна. Тиймээс 2011 оны дэлхийн хүний хөгжлийн илтгэл нь хүрээлэн буй орчны тогтвортой хөгжил болон эрх тэгш байдлын харилцан шүтэлцээнд үндэслэн, хөгжлийн чиглэлээ тодорхойлон хэрэгжүүлэх замд газарчлах хөтчийн үүрэг гүйцэтгэнэ гэдэгт найдаж байна.

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр хэрэгжиж буй дэлхийн 176 улс орон, бүс нутагт амьдарч буй ядуу буурай олон хүн ядуурал гачигдлын асар их дарамтан дор амьдарч байна. Ийм улс орнуудад байгаль орчны доройтлоос улбаалан гарч буй дарамт улам бүр нэмэгдэж байгаа ч түүнтэй тэмцэх арга зам хараахан хомс байгаа тул ядуу иргэд нь байгаль орчны доройтолд илүү их өртөж, хор уршгийг нь амссаар байна. Ядуу буурай оронд хүмүүс ахуйн болон ариун цэврийн шаардлага хангаагүй нөхцөлд амьдарч байгаа бөгөөд байгаль орчны доройтол, нийгмийн тэгш бус байдал цаашид даамжирсаар байвал өмнөх жилүүдэд хүний хөгжлөөр гаргасан ахиц дэвшлийн хурд саарч, уруудан доройтож болзошгүй байгааг урьдчилсан төлөв байдлын судалгаанууд анхааруулж байна.

Эрх мэдлийн тэгш бус байдал нь ийм нөхцөл байдлыг улам даамжруулж байна. Шинэчилсэн судалгаагаар үндэсний хэмжээнд тооцсон цэвэр усны хангамж, эрүүл ахуйн стандарт нөхцлөөр хангагдсан хүн ам, газрын доройтолд нэрвэгдсэн хүн ам, агаарын бохирдлоос үүдэлтэй хүн амын эндэгдэл зэрэг үзүүлэлтэд эрх мэдлийн болон жендэрийн тэгш бус байдал ихээхэн нөлөөтэй байгаа нь харагдаж байгаа бөгөөд энэ нөлөө нь орлогын тэгш бус байдал гүнзгийрэхэд нөлөөлж байна. Жендэрийн тэгш бус байдал нь байгаль орчин доройтох тусам ихсэж байгаагаас гадна засаглалын бүтэц, тогтолцоо нь ихэвчлэн хөгжиж буй орнууд, хүн амын эрсдэлд эмзэг хэсэг үзэл бодлоо илэрхийлэх боломжийг хязгаарлаж байна.

Гэхдээ хөгжлийн тэгш бус болон тогтворгүй байдалтай тэмцэх арга замууд бий. Малтмал түлшний хэрэглээнд тулгуурласан өсөлт нь хүний хөгжлийн үзэл баримтлалын дагуу сайн сайхан амьдралд хүргэх урьдчилсан нөхцлийг бий болгож чадахгүй. Нөхөн сэргээгдэх эрчим хүч, цэвэр усны хангамж, эрүүл ахуйн нөхцөл, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тэгш байдлыг хангахад чиглэсэн хөрөнгө оруулалт хийснээр тогтвортой хөгжил болон хүний хөгжлийн үзүүлэлтийн аль алиныг нь нэмэгдүүлж чадах юм. Түүнчлэн иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн оролцоог идэвхжүүлэх замаар ардчиллын үйл явц болоод үүрэг хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож чадна.

Энэ чиглэлд нийгмийн эмзэг бүлгүүдийн эрх ашгийг хамгаалан дэмжиж ажилладаг олон нийтийн байгууллагуудын оролцоог идэвхжүүлэх, яам, агентлаг болон хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага хоорондын төсөв, үйл ажиллагааны уялдааг сайжруулах аргууд ихээхэн үр дүнтэй юм.

Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж дуусах 2015 оноос дэлхийн улс орнууд эрх тэгш зарчимд үндэслэсэн тогтвортой хөгжилд хүрэх зорилтыг тодорхойлон мөрдөх хэрэгцээтэй тулгарах нь зайлшгүй. Рио+20-ийн үзэл баримтлалыг даган дэлхийн улс орнууд энэ хэрэгцээг амжилттай шийдвэрлэн, ирээдүйд хэрхэн урагшлан хөгжих талаар нэгдсэн ойлголтод хүрэх боломжтой юм. 2011 оны Дэлхийн Хүний Хөгжлийн Илтгэлд тодорхойлсноор тэгш байдлын асуудлыг улс орнуудын бодлого, хөтөлбөрүүдэд уялдуулан тусгаж, хууль эрх зүй, бодлогын тогтолцоог шинэчлэн боловсронгуй болгоход ард иргэдийг татан оролцуулах зэрэг аргыг ашиглан маш сайн үр дүнд хүрч чадахыг олон орны туршлага нотлон харуулж байна.

Байгаль орчин, нийгмийн хамгаалал зэрэг хөгжлийн бүх асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн хэмжээ өнөөгийн албан ёсны хөгжлийн туслалцааны санхүүжилтээс хэд дахин их байх ёстой юм. Тухайлбал нүүрстөрөгч бага ялгаруулдаг эрчим хүчний эх үүсвэрт зарцуулж буй зардал нь хамгийн бага хэрэглээгээр тооцсон хөрөнгийн ердөө 1,6 хувьтай тэнцэж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, түүнийг сааруулахад зарцуулж буй хөрөнгө нь тооцоолон бодсон нийт хэрэгцээний 11 хувийг л хангаж чадаж байна.

Уур амьсгалын асуудалд илүүтэй анхааран хөрөнгө төсөв ахиу төлөвлөн зарцуулна гэдэгт бид итгэж байна. Зах зээлийн механизм, хувийн хэвшлээс орж ирэх санхүүжилт маш чухал үүрэгтэй бөгөөд төрийн зүгээс тэдний үйл ажиллагааг төсвийн хөрөнгө оруулалт болон бусад хөшүүрэг арга хэмжээгээр дэмжиж ажиллах нь зүйтэй. 2011 оны Дэлхийн Хүний Хөгжлийн Илтгэлд дурьдсанчлан, хөрөнгө санхүүг хүрэлцэхүйц хэмжээнд шийдэхийн тулд шинэлэг сэтгэлгээгээр хандах эрэл хайгуул хийх хэрэгтэй.

2011 оны дэлхийн Хүний Хөгжлийн Илтгэлд байгаль орчны тулгамдсан аюул эрсдэлийг эрх тэгш зарчмын дагуу бууруулахад хөрөнгө санхүүгийн шинэ эх үүсвэрийг бий болгоход чиглүүлэн хэлэлцүүлэг өрнүүлэх, тэгш байдал болон бүх оролцогчдын дуу хоолойг нэмэгдүүлэх, оролцоог идэвхжүүлэхийн чухлыг сануулсан байна. Түүнчлэн санхүүгийн урсгал нь тогтворгүй болоод тэгш бус байдлыг үүсгэж буй хамгийн гол бөгөөд тулгамдсан асуудалд анхаарлаа чиглүүлэн, өнөөгийн оршин буй нөхцөл байдлыг дордуулахгүй байхад анхаарвал зохино.

Боломж бололцоог бүгдэд тэгш хүртээх нь хүний хөгжлийн үндсэн зорилго юм. Бид бүхний өнөөдөр болон ирээдүй хойч үед эмзэг тэгш бус байдалтай байнга тэмцэх, улмаар бууруулах хамтын үүрэг харууллага тулгарч байна. Бид ирээдүй хойч үедээ өнөө үе бол ирээдүйнхээ дайсан биш гэдгийг нотлон харуулах хэрэгтэй. Энэхүү хүний хөгжлийн илтгэл нь энэ бүхнийг харгалзан цаашдын арга замаа тодорхойлоход бидэнд туслах болно.



ХЕЛЕН КЛАРК

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Захирагч

Энэхүү илтгэлд гарсан дүгнэлт, зөвлөмж нь НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр буюу Захирлуудын Зөвлөлийн үзэл бодлыг шууд тусгаагүй бөгөөд илтгэл тайлангийн судалгаа, боловсруулалт нь Хүний хөгжлийн илтгэлийн газрын дарга хатагтай Жени Клузманы удирдсан ажлын хэсэг болон чадварлаг зөвлөх багийн бие даасан хамтын бүтээл болно.

АГУУЛГА

Өмнөх үг
Талархал

ЕРӨНХИЙ ТОЙМ

БҮЛЭГ 1

Яагаад тогтвортой хөгжил, эрх тэгш байдлыг хангахад анхаарах нь чухал вэ?

Хүний хөгжлийг хязгаарлаж буй хүчин зүйл бий юу?
Тогтвортой хөгжил, эрх тэгш байдал, хүний хөгжил
Бидний анхаарах гол асуудал

БҮЛЭГ 2

Хүний хөгжил, тогтвортой байдал болон тэгш байдлын үзүүлэлтийн хэв загвар болон чиг хандлага

Амжилт болон хэтийн төлөв
Тогтвортой байдлын амжилтад саад учруулж буй хүчин зүйл
Хүний хөгжил, тогтвортой байдал болон тэгш байдлын үзүүлэлтэд гарч буй амжилт

БҮЛЭГ 3

Асуудлыг шийдвэрлэх – дээрх үзүүлэлтийн хамаарлын тухай ойлголт

Ядуурлын судалгаанууд
Байгаль орчны доройтол хүний хөгжлийн зарим үзүүлэлтэд сөргөөр нөлөөлөх нь
Цаг агаарын гэнэтийн үзэгдлийн сөрөг нөлөө
Эрх мэдлийн тэгш бус байдал болон байгаль орчны доройтол

БҮЛЭГ 4

Эерэг үр дүнгүүд- хүний хөгжил, тогтвортой хөгжил, тэгш байдлын цогц стратеги

Байгаль орчны доройтлыг бууруулж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь
Байгаль орчны доройтлоос сэргийлэх нь
Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг сааруулах

БҮЛЭГ 5

Бодлого боловсруулах нь хөгжлийн загварыг эргэн нягталж, өөрчлөлт хийх нь

Санхүүгийн хөрөнгө оруулалт, бодлогын шинэчлэлт
Олон улсын түвшинд шинэчлэл хийх нь

Тэмдэглэл Эх сурвалж

СТАТИСТИК ХАВСРАЛТУУД

Хэрэглэгчийн гарын авлага
Дэлхийн улс орнуудын ХХИ, эзлэх байр, 2011

Статистик хүснэгтүүд

1. Хүний хөгжлийн индекс болон түүний бүрэлдэхүүн хэсгүүд
2. Хүний хөгжлийн индекс, түүний чиг хандлага, 1980-2011
3. Тэгш бус байдлыг нэмж тусгасан хүний хөгжлийн индекс
4. Жендэрийн тэгш бус байдлын индекс
5. Олон хэмжүүрт ядуурлын индекс
6. Байгаль орчны тогтвортой байдал
7. Байгаль орчны доройтол хүний хөгжилд нөлөөлөх нь
8. Сайн сайхан байдал болон байгаль орчны ойлголт
9. Боловсрол, эрүүл мэнд
10. Хүн ам эдийн засаг

Тэмдэглэл Бус нутгууд Статистикийн нэр томъёоны тодорхойлолт

Ерөнхий тойм

2011 оны Дэлхийн Хүний Хөгжлийн Илтгэлийн гол сэдэв нь тогтвортой хөгжил болон эрх тэгш байдлын асуудал юм. Олон судалгааны дүнгээс харахад байгаль орчны доройтол болон хүний хөгжлийн үзүүлэлт дэх тэгш бус байдал нь харилцан хамааралтай байна. Хүрээлэн буй орчны бохирдол эмзэг ядуу иргэдэд хүндээр тусч тэгш бус байдлыг даамжруулж байхад хүний хөгжлийн үзүүлэлт дэх тэгш бус байдал нь байгаль орчныг улам доройтуулж байна.

Хүмүүсийн сонголт хийх боломж бололцоог өргөжүүлэхэд чиглэсэн хүний хөгжлийн үзэл баримтлал нь байгалийн баялгийг хамтран ашиглаж, үр шимийг нь хүртэх зарчимд суурилдаг. Иймд орон нутаг, улс үндэстэн болон олон улс зэрэг бүх түвшинд хүний хөгжлийг дэмжих аливаа үйл явцад хүн амыг эрх тэгш оролцуулж, дуу хоолойг нь сонсож байх ёстой.

Бид байгаль орчны тогтвортой байдлыг хангах хөгжлийн үйл явцыг хэрэгжүүлэхэд ядуу иргэдийн амьдрал ахуйгаа сайжруулах хүсэл эрмэлзлэлийг нь харгалзан үзэх хэрэгтэй. Түүнчлэн бид аливаа улс орон харилцан шүтэлцээ бүхий зарчимд үндэслэн тогтвортой хөгжил болон эрх тэгш байдлыг дэмжих хөгжлийн замналаар замнахад нь дэмжлэг үзүүлэх ёстой.

Яагаад тогтвортой хөгжил, эрх тэгш байдлыг хангахад анхаарах нь чухал вэ?

Хүний хөгжлийн үзэл баримтлал нь цаг хугацаанаас үл хамааран эх дэлхий оршин тогтнох, хөгжин дэвжих явцад тулгамдаж буй асуудлуудтай нягт уялдан байдаг. 2010 оны Дэлхийн Хүний Хөгжлийн Илтгэлээр хүний хөгжлийн үзэл баримтлалыг зарлан тунхаглахдаа тэгш байдал, эрх мэдэл, тогтвортой хөгжил нь хүний сонголт хийх бололцоог өргөжүүлдэг талаар онцгойлон тэмдэглэж, үүнтэй холбоотой хүний хөгжлийн ямар асуудлууд урган гарч ирдгийг тодорхойлов.

Тогтвортой хөгжил ба эрх тэгш байдлыг хамтад нь авч үзэх шалтгаан

2011 оны илтгэлд бид байгаль орчны тогтвортой хөгжил болон тэгш байдлын хоорондын уялдаа холбоогч нягтлан судалсан билээ. Байгаль орчны тогтвортой хөгжил болон тэгш байдлын аль аль нь шударга хуваарилалтын зарчимд үндэслэж байдаг. Тогтвортой хөгжил өнөө үеийнхний боломж бололцоог хангахдаа ирээдүй

үеийн боломжийг золиослохгүй байх үндсэн зарчимд тулгуурлаж байдаг тул бидэнд тун чухал ач холбогдолтой ойлголт билээ. Тэгш бус байдлыг үүсгэж буй бүх үйл явц шударга бус байдаг ба гадны аливаа хүчин зүйлс нь хүмүүсийн амьдрал ахуйгаа сайжруулах сонголтыг хязгаарлах ёсгүй билээ. Нэн ялангуяа хүмүүсийг хүйс, арьс өнгө, төрсөн газар нутгаар нь ялгаварлан гадуурхаж, тэгш бус хандаж байгаа нь туйлын шударга бус явдал юм.

Арав гаруй жилийн өмнө Судхир Ананд болон Амаргья Сен нар тогтвортой хөгжил болон эрх тэгш байдлыг яагаад хамтад нь авч үзэх ёстой тухай ийнхүү тайлбарлажээ. Тэд “бид эрх тэгш байдлыг зөвхөн одоо, ирээдүй үе хоорондын гэсэн хэмжүүрээр л авч үзэх юм бол дэлхийн нийтлэг зарчмаас гажсан явдал болно. Бид үүнийг одоо, ирээдүй үеийнхэн дотор нь бас авч үзэх ёстой” гэжээ. Үүнтэй адил санааг Брунтландын комиссын 1987 оны илтгэл, 1972 оны Стокгольм болон 2002 оны Йоханнесбургийн тунхаглалд дэвшүүлжээ. Гэхдээ өнөөдөр тогтвортой хөгжлийн тухай ярихдаа эрх тэгш байдлыг огоорч, энэ хоёр асуудлыг ямар ч холбоогүй тусад нь авч үзсэнээр үндэслэл муутай, бие биенээ үгүйсгэсэн шинж чанартай болгож байна.

Үндсэн тодорхойлолтууд

Хүний хөгжил гэдэг нь эрхэмлэн зорьж буй сайн сайхан амьдралд хүрэхийн тулд хүний сонголт хийх өргөн боломж, чадварыг нэмэгдүүлэхэд чиглэдэг. Хүний бодит эрх чөлөөг нэмэгдүүлж, тэдний чадварыг дээшлүүлэх нь тэдний үндсэн хэрэглээг хангахдаа хамаагүй өргөн хүрээний ойлголт юм. Сайн сайхан амьдралд чиглэсэн олон үнэт зүйл, хэмжүүр бий, тухайлбал бид амьдрал ахуйд маань хэр нөлөөтэй эсэхийг үл харгалзан биологийн олон янз байдал эсхүл байгалийн өнгө үзэмжийг ихээхэн үнэлэн эрхэмлэдэг байж болох юм.

Эмзэг ядуу хүмүүс нь хүний хөгжлийн анхаарлын төвд байх ёстой. Өнөөдөр бидний хийж байгаа буруу үйл ажиллагааны хор хохирлыг амсах ирээдүй хойч үеийнхэн ч хүний хөгжлийн анхаарлын төвд байх ёстой. Бидний хийж буй, эсхүл хийхээр төлөвлөж буй аливаа үйл ажиллагаа ялангуяа ядуу хүмүүст хор уршигтай байвал ямар үр дагавар бодитойгоор нүүрлэж байгаа, эсхүл нүүрлэж болох асуудлыг хүний хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд тодорхойлохыг хичээдэг.

Хүний хөгжлийн тогтвортой байдал нь өнөөгийн хүмүүсийн эрх чөлөөг нэмэгдүүлэхийн сацуу ирээдүй үеийнхний эрх чөлөөг хязгаарлахгүй байхад анхаардаг.

Байгаль орчны тогтвортой хөгжлийн талаар өрнөж буй хэлэлцүүлэг нь хүний гараар бүтсэн баялаг нь байгалийн баялгийг орлож чадах эсэх, хүний оюун ухаан, ур чадвар нь байгаль, байгалийн баялгийг нөхөн сэргээж, эргээд хэвэнд нь оруулж чадах эсэх гэсэн хоёр асуудалд төвлөрч байна. Ирээдүйд ийм боломж гарах эсэх нь үл мэдэгдэх, гамшиг сүйрлийн эрсдэл зэрэг хүчин зүйлээс улбаалан байгалийн унаган төрх, баялгийг хадгалан хамгаалах байр суурь зонхилох хандлагатай байна. Энэхүү үзэл баримтлал нь хүний эрхэд суурилсан хөгжлийн үзэл баримтлалтай нийцэж байна. *Хүний хөгжлийн тогтвортой байдал нь өнөөгийн хүмүүсийн эрх чөлөөг нэмэгдүүлэхийн сацуу ирээдүй үеийнхний эрх чөлөөг хязгаарлахгүй байхад анхаардаг.* Хүний хөгжлийн тогтвортой байдлыг дэмжихийн тулд оновчтой хэлэлцүүлэг өрнүүлж санал бодлоо солилцон нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлүүдийг тодорхойлох ёстой (Зураг 1).

Байгаль орчны тогтвортой хөгжил болон эрх тэгш байдал нь бие биенээ дэмжин тэтгэх байнгын харилцан шүтэлцээтэй байдаггүй. Энэ хоёрыг тэнцвэртэй байлгахад ихэнхдээ хүндрэлтэй байдаг. Тухайлбал, хөгжиж буй оронд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа нь эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж, энэ нь тэгш байдлын үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж болно.

2011 оны Дэлхийн Хүний Хөгжлийн Илтгэлд байгаль орчин болон тэгш байдалд нөлөөлөх нөлөөллийг бодлогоор зохицуулж болох хувилбаруудыг танилцуулж байна. Дэвшүүлж буй хувилбаруудын дунд байгаль орчин болон эрх тэгш байдал харилцан эерэгээр нэг нэгэндээ нөлөөлж болох хувилбаруудыг тодорхойлоход онцгой анхаарал хандуулж, хэрхэн тэнцвэртэй байж болох талаар өгүүлсэн байна. Бид тогтвортой хөгжил, эрх тэгш байдал, хүний хөгжил гэсэн 3 асуудлыг аль нэгийг нь орхигдуулалгүй хэрэгжүүлж болох хувилбаруудыг судалж байна.

ЗУРАГ 1

Тогтвортой хөгжил болон эрх тэгш байдал хоорондын харилцан шүтэлцээ болон бодлогын үйлчлэл

Энэ үйл ажиллагаа тогтвортой хөгжил болон тэгш байдлыг хослуулан бий болгох зорилгын эерэг үр дүнг тодорхойлж, тэнцвэртэй байлгахад онцгой анхаарал хандуулав.



Амжилт болон хэтийн төлөв

Дэлхий дахинд нүүрлэж буй байгаль орчны доройтол улам даамжирч, цаашид ч өсөн нэмэгдэх талаар олон баримт бичигт өгүүлж байна. Ирээдүйд байгаль орчны доройтол аль түвшинд хүрэх нь тодорхой бус учир бид урьдчилсан дүн шинжилгээ хийж, хүний хөгжлийн асуудалд энэ талаар тусгах хэрэгтэй юм.

2011 оны Дэлхийн Хүний Хөгжлийн Илтгэл нь сүүлийн жилүүдэд улс орнуудад гарч буй ахиц дэвшлийн талаар мэдээлэхийн сацуу дараах гурван сэрэмжлүүлийг өгч байна. Үүнд:

- Хүн амын орлого өсөн нэмэгдэж байгаа ч байгаль орчны доройтлыг илтгэх үндсэн гурван үзүүлэлт буюу нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалт, хөрс, усны бохирдол, ойн хомсдол доройтол ихсэж байна.
- Олон оронд эрүүл мэнд, боловсролын үзүүлэлтээр ахиц дэвшил гаргаж байгаа ч орлогын тэгш бус хуваарилалт нэмэгдэж байгаа хандлага ажиглагдаж байна.
- Дэлхийн хүний хөгжлийн индекс нэмэгдэж байгааг дагаад жендэрийн тэгш байдлын дундаж үзүүлэлт өсч байгаа ч улс орнуудад харилцан адилгүй байна.

Дэлхийн дулаарал хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлөн, цэвэр усны хангамж, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд байгаа хүн амын тоо буурах, бохирдол ихсэх зэрэг нөхцөлд дэлхийн хүний хөгжлийн индекс 2050 он гэхэд 8 хувиар ухрах төлөвтэй байна (Өмнөд Ази, Сахарын цөлөөс урагш Африкт Хүний хөгжлийн индекс - ХХИ нь 12 хувиар ухарна).

Ойн хомсдол, газрын доройтол, биологийн олон янз байдлын хомсдол болон уур амьсгалын эрс тэс нөхцөл зэрэг байгалийн гамшгууд таамаглаж байсан хэмжээнээс илүү олон тохиовол ХХИ урьдчилан тооцоолж гаргасан дүнгээс даруй 15 хувиар буурах хандлагатай байна.

Хэрэв бид байгаль орчны доройтлыг бууруулж улмаар зогсоох хүртэл дорвитой алхам хийхгүй бол ирээдүй хойч үе маань Зураг 2-т тооцсон хэмжээний хохирлыг амсана. Байгаль орчны доройтлын улмаас 2050 он гэхэд хүний хөгжлийн түвшинд эерэгээр хөгжингүй орнуудын түвшинд ойртон очиж байсан хөгжиж буй орнуудын гаргасан ахиц дэвшил талаар болж, буурах хандлага ажиглагдаж байна.

Хямралаас урган гарах сөрөг үр дагавар нь байгаль орчныг доройтуулахад бараг оролцоогүй буурай иргэдэд илүү хүнд тусгах хандлагатай байгааг урьдчилсан дүн шинжилгээ нотолж байна. Тухайлбал, ХХИ-ийн үзүүлэлтээр доогуур түвшинд байгаа улс орнууд дэлхийн дулааралд хамгийн бага нөлөө үзүүлсэн хэдий ч түүнээс үүдэн гарах сөрөг нөлөөлөл буюу хур тунадас багасгах,

биологийн олон янз байдлын хомсдол, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл буурах, амьжиргааны түвшин доройтоход хамгийн их өртөж болзошгүйг Зураг 3-т харууллаа.

Хүний хөгжлийн түвшнээр дээгүүр улс орнуудад нэг хүнд ногдох CO₂ (нүүрстөрөгчийн давхар ислийн) ялгаруулалт ХХИ-ийн үзүүлэлт дунд зэрэг болон доогуур улс орнуудынхаас харьцангуй өндөр байна. Энэ нь ХХИ-ийн түвшин дээгүүр, баян чинээлэг улс оронд амьдарч буй хүмүүсийн эрчим хүчний хэрэглээ тухайлбал унаа машин, агааржуулах, халаах болон хөргөх систем, боловсруулсан болон савласан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ их байгаатай шууд холбоотой юм.


ХХИ-ийн түвшин хамгийн дээгүүр улс орны нэг хүн ХХИ-ийн дундаж түвшинтэй улс орны нэг хүнээс дөрөв дахин их нүүрстөрөгчийн давхар исэл, хоёр дахин их намгийн хий болон азотын исэл ялгаруулдаг бол нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалтаар ХХИ-ийн түвшин доогуур улс орны нэг хүнээс даруй 30 дахин их байна. Их Британий Нэгдсэн Вант улсын нэг иргэн ХХИ-ийн түвшин доогуур улс оронд амьдарч буй нэг иргэнд ногдох бүтэн жилийн турш ялгаруулах хүлэмжийн хийг ердөө хоёр сарын дотор ялгаруулдаг байна. Ийм хэмжээний нүүрстөрөгчийн давхар ислийг нэг хүнд ногдох ялгаруулалтаар хамгийн өндөрт тооцогддог Катар улсын иргэн ердөө арван хоногт ялгаруулж байна.

1970 оноос хойш CO₂ ялгаруулалтын дөрөвний гурвыг ХХИ-ийн түвшин доогуур, дундаж болон дээгүүр орнууд эзэлж байгаа бол хүлэмжийн хийн ялгаруулалтын дийлэнх хэсгийг зөвхөн ХХИ-ийн түвшин дээгүүр орнууд бүрдүүлж байна. Гэхдээ дээрх тооцоог гаргахдаа чинээлэг орнууд руу бүтээгдэхүүн экспортлодог буурай орнуудад нүүрстөрөгчийн давхар ислийг их хэмжээгээр ялгаруулдаг үйлдвэрлэлийн хэмжээг шилжүүлэн тооцсон дүнг оруулаагүй болно.

Дэлхийн ХХИ-ийн үзүүлэлт бүхэлдээ өсч байгаа боловч голдуу эдийн засгийн өсөлтөөс шалтгаалсан байгаль орчны доройтол зэрэгцэн явагдаж байна. Зураг 4-т үзүүлсэн 1 болон 3 дахь шугамын хоорондын ялгааг харьцуулна уу. Эхний шугам нь ерөнхийөө орлого өндөртэй улс орнуудын нэг хүнд ногдох нүүрстөрөгчийн давхар ислийн хэмжээ их байдаг гэдгийг харуулж байна. Харин 3 дахь шугамнаас харахад нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалт нь ХХИ-ийн үндсэн үзүүлэлтүүд болох боловсрол, эрүүл мэнд зэрэгтэй уялдаа холбоогүй болох нь харагдаж байна. Нүүрстөрөгчийн давхар ислийг агаар мандалд ялгаруулж буй бүх үйл ажиллагаа нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй холбоотой, харин боловсрол, эрүүл мэндийн салбартай төдийлэн холбоогүй харагдаж байгаа юм.

ЗУРАГ 2

2050 он гэхэд байгаль орчны доройтлын хүний хөгжилд үзүүлэх нөлөөг тодорхойлсон урьдчилсан прогнозыг



Тэмдэглэл: Урьдчилсан прогнозын тайлбарыг харна уу.


Эх сурвалж: В.Hughes, M.Irfan, J.Moyer, D.Rothman, J.Solorzano нарын болон ХХИГ-н тоо мэдээнд үндэслэн хийсэн ХХИГ-н тооцоо, 2011 он “Байгаль орчны доройтлын хүний хөгжилд үзүүлэх нөлөөллийн урьдчилсан таамаглал”, “Хүний хөгжлийн судалгааны баримт, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Нью Йорк, хувилбар 6,42”

Эдгээр дүн шинжилгээнээс харахад нэг хүнд ногдох нүүрстөрөгчийн давхар ислийн дундаж хэмжээ нь ХХИ-ийн үзүүлэлтүүдтэй ямар ч холбоогүй болох нь харагдаж байна. ХХИ-ийн үзүүлэлт доогуур байхад дээрх шугаманд маш бага эсвэл бүр ямар ч өөрчлөлт гарахгүй байхад, ХХИ өсч хэлбэлзлийн цэгт хүрэх үед нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалт болон орлогын хооронд маш том эерэг харьцаа байгааг олж харж болно. ХХИ-ийн түвшнийг хурдацтай нэмэгдүүлж байгаа улс орнуудын нэг хүнд ногдох нүүрстөрөгчийн давхар ислийн хэмжээ дагаад өсч байна. Эдгээр өөрчлөлт нь өнөөгийн хөгжлийн улмаас маргааш ямар үр дагавар гарч болохыг харуулж байна. Давтан хэлэхэд орлогын өөрчлөлт нь энэ чиг хандлагыг бий болгож байгаа юм.

Гэхдээ энэ хамаарал нь байгаль орчны бүх үзүүлэлтээр ажиглагддаггүй. Тухайлбал, бидний хийсэн дүн шинжилгээнд ХХИ болон ойн хомсдол хоорондын эерэг хамаарал тун бага. Нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаруулалтыг байгаль орчны бусад доройтлын хэлбэрээс яагаад тусад нь авч үзээд байна вэ?

Температурын өсөлт, хур тунадасын бууралт

Уур амьсгалын хувьсах чанарын түвшин, өөрчлөлт, ХХИ-ийн түвшнээр



Тэмдэглэл: 1951-1980 болон 2000 оны хоорондох уур амьсгалын өөрчлөлтийн хэлбэлзлийн коэффициентууд өөр өөр байна. 1951-1980 оны хүн амын дундаж хэмжээгээр тооцов.

Эх сурвалж: Delaware-н их сургуулийн тоо мэдээнд суурилсан ХХИГ-ны тооцоо

Бидний үзэж байгаагаар байгаль орчин болон амьдралын стандарт хоорондоо шууд хамааралтай байгаа бол хөгжингүй орнуудын байгаль орчны үзүүлэлтүүд сайн, бөгөөд энэ хамаарал сул байна.

Байгаль орчны эрсдэл болон ХХИ-ийн хоорондын хамаарлыг судалж үзээд бид дараах гурван дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1. Өрхийн түвшин дэх байгаль орчны доройтолд агаарын бохирдол, цэвэр ус болон эрүүл ахуйн таагүй нөхцөл зэрэг багтаж байгаа бөгөөд ХХИ-ийн түвшин доогуур байгаа оронд эдгээр үзүүлэлт илүү хурцаар илэрч, ХХИ нэмэгдэх тусам нөхцөл сайжирч байдаг.
2. Улс орны түвшинд хот суурины агаарын бохирдол зэрэг байгаль орчны доройтол нь хөгжлийн чиг хандлагыг эхлээд

өсгөж, дараа нь бууруулах замаар урвуу байрлалтай U хэлбэрийн муруй үүсгэдэг байна.


3. Дэлхийн түвшин дэх байгаль орчны эрсдэлд хүлэмжийн хийн ялгаруулалтыг оруулж тооцох бөгөөд энэ нь ХХИ-ийн үзүүлэлт өсвөл дагаад өсдөг байна. ХХИ нь өөрөө эдгээр өөрчлөлт бий болоход нөлөөлсөн жинхэнэ шалтгаан биш. Эдийн засаг, орлогын өсөлт нь хорт хийн ялгаралтыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байгаа боловч түүнийг үүсгэгч хүчин зүйл биш юм. Илүү олон хүчин зүйл хавсарч байж дээрх өөрчлөлтүүдийг бий болгодог. Тухайлбал, олон улсын худалдааны гэрээгээр байгаль орчныг бохирдуулагч бүтээгдэхүүний үйлдвэрлэлээ өөр оронд шилжүүлэн байрлуулах, байгалийн баялгийг ашиг олох зорилгоор их хэмжээгээр олборлон ашиглах, хот, хөдөөгийн байгаль орчны нөхцөл байдлын ялгаа зэрэг нь байгаль орчны өөрчлөлтүүдийг бий болгоход нөлөөлдөг. Эндээс харахад улс төрийн бодлого, шийдэл маш чухал үүрэгтэй байна.

Дээр дурьдсан байгаль орчны доройтлоос зайлсхийх боломж бий. Олон орон байгаль орчны тогтвортой, тэгш байдал болон ХХИ-ийн түвшнээ үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, гайхамшигтай ололт амжилт гаргаж байна. Байгаль орчны тогтвортой байдлын үзүүлэлтээр бүс нутгийн болон олон улсын түвшинд дээгүүрт тооцогдох ахиц дэвшил гаргасан улс орнуудыг олон хэмжүүрт үзүүлэлтээр дүгнэж тодруулдаг стратеги төлөвлөгөөг бид санал болгож байна. Тэдгээр олон хэмжүүрт шалгуур үзүүлэлтэд: эрх тэгш байдал болон ХХИ-ийн өсөлт, агаарын бохирдлыг бууруулах болон цэвэр усны хангамж сайжирсан байдал зэрэг багтах юм (Хүснэгт 1). Байгаль орчны тогтвортой байдлыг хүлэмжийн хийн ялгаруулалт хир буурсан, цэвэр усны зохистой хэрэглээ хэрхэн нэмэгдсэн, ойн хомсдол хэдий хэмжээгээр буурсан зэрэг үзүүлэлтэд үндэслэн тодорхойлно. Судалгааг хийхдээ нэг биш хэд хэдэн талаас нь авч үзсэн тоо баримт, мөн харьцуулж болох боломжит бүх асуудлыг тусгасан учир гарсан дүн нь тойм төдий бус харин бодитой болж чадсан.

ЗУРАГ 4

Нэг хүнд ногдох нүүрстөрөгчийн давхар ислийн хэмжээ нь ХХИ-ийн орлогын хүчин зүйлтэй эерэг бөгөөд хүчтэй хамааралтай байхад эрүүл мэнд, боловсролын үзүүлэлттэй хамааралгүй байна.

Нэг хүнд ногдох CO₂ (тонн)



Тэмдэглэл: 2007 оны тоо мэдээ
Эх сурвалж: ХХИГ-ын тооцоо

Дээрх аргаар судалгаа хийж үзэхэд ердөө ганцхан улс болох Коста Рика бүх шалгуур үзүүлэлтүүдээр бүс нутгийнхаа дундаж түвшнээс өндөр байсан бол ХХИ-ийн түвшин өндөр бусад гурван орон олон хэмжүүрт үзүүлэлтүүдээр бүгд тухайн бүс нутагтаа тэргүүлж чадаагүй. Тухайлбал, Швед Улс ойн нөхөн сэргээлтийн үзүүлэлтээр бүс нутагтаа төдийгүй олон улсын түвшинд тэргүүлж байна.

Улс орнуудыг бүс нутгаар, хөгжлийн үе шатаар, бүтэц зохион байгуулалтаар харьцуулан судлахад бүх орон байгаль орчны тогтвортой, эрх тэгш байдал, ХХИ-д оруулан тооцдог үндсэн үзүүлэлтүүдээ харгалзан бодлогоо боловсруулах боломжтой байна. Бид улс орнуудын амжилт гаргахад нөлөөлсөн бодлого, хөтөлбөрүүдийг судлах явцдаа орон нутгийн онцлог, ач холбогдлыг мөн давхар авч үзэж байгаа билээ.

Гэхдээ сүүлийн жилүүдэд ажиглагдаж буй чиг хандлагаас үзэхэд хэд хэдэн үзүүлэлтээр байгаль орчин доройтож, хүний хөгжилд нэн ялангуяа амьжиргаагаа залгуулахын тулд байгалийн нөөц баялгаас шууд хамааралтай байгаа олон сая хүнд маш хүнд тусч байна.

- Дэлхийн хэмжээнд хөрс элэгдэн, үржил шим нь буурч, бэлчээр талхлагдсаны

улмаас нийт газрын 40 хувь нь доройтсон байна. Энэ үзэгдэл хамгийн хурц явагдаж байгаа бүс нутгуудад ургац ойролцоогоор 50 хувиар буурсан нь газрын үржил шим доройтсонтой холбоотой.

- Усны хэрэглээний 70-85 хувь хөдөө аж ахуйн салбарт ноогддог бөгөөд үр тарианы үйлдвэрлэлийн салбарын 20 хувь усыг гамгүй, зохисгүй хэрэглэж байгаа нь ирээдүйд хөдөө аж ахуйн салбар өсөж дэвжихэд саад учруулж байна.
- Ойн доройтол бол дэлхий дахинд тулгамдсан асуудал мөн. 1990-2010 оны хооронд Латин Америк, Карибын бүс нутаг, Сахарын цөлөөс урагш бүсийн орнуудад ойт бүсийн хамрах хэмжээ хамгийн их хорогдсон байна. Энэ аюул Арабын орнуудад ч мөн нүүрлэж байна (Зураг 5). Харин бусад бүс нутагт ойн нөхөн сэргээлтийн түвшинд бага хэмжээний өсөлт ажиглагджээ.
- Дэлхийн нийт хүн амын гуравны нэг нь аж төрдөг гандуу бүс нутагт цөлжилтийн аюул нүүрлээд байна. Үүнээс байгаль орчны доройтолд эмзэг өртөмтгий, байгаль орчны өөрчлөлтөд дасан зохицох чадвар сул Сахарын цөлөөс урагш бүсийн орнуудад хамгийн хүндээр тусах юм.

ХҮСНЭГТ 1


Байгаль орчин, эрх тэгш байдал, хүний хөгжлийн үзүүлэлтийн түвшингээр хамгийн өндөр улс орнууд, сүүлийн үеийн тоо мэдээгээр

Улсын нэр	Олон улсын тулгамдсан асуудал			Орон нутгийн нөлөө		Тэгш байдал болон хүний хөгжил	
	Хүлэмжийн хийн ялгаруулалт	Ойн хомсдол	Усны хэрэглээ	Усан хангамж	Агаарын бохирдол	ХХИ (бүс нутгийн дунджаар)	Нийт бууралт (бүсийн дундаж хувь)
Коста Рика	√	√	√	√	√	104	77
Герман		√	√	√	√	103	91
Филиппин	√	√		√	√	103	89
Швед		√	√	√	√	102	70

Тэмдэглэл: Дэлгэрэнгүй илтгэлд тодорхойлсон (Бүлэг 2, Тэмдэглэл 80) шалгуураар эдгээр орнуудыг эрэмбэлсэн бөгөөд дээрх 3 үзүүлэлтээр ХХИ-ийн дундаж түвшинтэй орнуудаас өндөр үзүүлэлттэй улс орнууд.

ЗУРАГ 5

Зарим бүс нутагт ой хорогдож, заримд нь ойг нөхөн сэргээж байна.



Эх сурвалж: Дэлхийн банкны 2011 оны тоо мэдээнд үндэслэн ХХИГ тооцов

Байгаль орчны доройтлын улмаас яваандаа дэлхийн хүнсний бүтээгдэхүүний үнэ 30-50 хувиар өсч, үнийн хөөрөгдөл их хэмжээгээр үүсэх магадлал өндөр байгаа нь ядуу өрхүүдэд хамгийн хүчтэй сөрөг нөлөө үзүүлэх юм. Байгаль орчинтой шууд холбоотой эдийн засгийн салбарууд болох хөдөө аж ахуй, загас агнуур, ойн аж ахуй, ан агнуур эрхэлдэг 1,3 тэрбум хүнд энэхүү доройтол нь хамгийн хурцаар тусах болоод байна. Байгаль орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийн улмаас нийгмийн бүх давхарга хоорондын тэгш бус байдал даамжирч болзошгүй юм. Энэ нь дараах хэд хэдэн шалтгаантай холбоотой:

- Хөдөөгийн иргэдийн дийлэнх хэсгийн орлогын эх үүсвэр нь байгалийн баялгаас шууд хамааралтай байдаг. Эрсдэл, хямралын үед амь зуухын тулд байгалийн баялаг ашиглах хүмүүсийн тоо нэмэгдэж ч болох юм.
- Байгаль орчны доройтол хүн амд хэр хүнд тусах нь тухайн орны иргэд байгалийн баялгаас цэвэр хамааралтай юу (байгалийн баялгийг олборлогч, хэрэглэгч), амин зуулгын шинжтэй, эсвэл ашиг олох зорилгоор байгалийн баялгийг ашиглаж байгаа эсэх, мөн гарч буй өөрчлөлтүүдэд хэр хурдан дасан зохицох, амьжиргааны өөр эх үүсвэртэй болох чадамж хэр байгаа зэргээс шалтгаална.
- Өдгөө 350 сая хүн ойн бүс нутагт эсхүл түүнийг бараадан амьжиргаагаа залгуулан, ашиг орлого олж байгаагийн дийлэнх

нь ядуу амьдарч байна. Ойн доройтол болон байгалийн нөөц баялгийг ашиглаж болох хэмжээнд хязгаарлалт хийх нь орлого багатай иргэдийн амьдралыг улам дордуулна. Олон орны туршлагаас харахад ойн баялаг ашиглан амьжиргаагаа залгуулдаг хүмүүсийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь давамгайлж байгаа нь тэд ажлын байраар хангагдах боломж бага, түлшний мод цуглуулах ажлыг голчлон хийдэгтэй холбоотой.

- Загас агнуур эрхэлж буй нийт 45 сая хүн байгаагийн 6 сая нь эмэгтэйчүүд бөгөөд ийм хүмүүс уур амьсгалын өөрчлөлтөд өртөх, загасны тоо толгой хомсдох эрсдэлд өртөж байна. Загас агнуур эрхлэн өдөр тутмын хоол тэжээлээ хангах, худалдан борлуулах, экспортлон гаргадаг орнуудад энэ эрсдэл нь илүү их байна. Тухайлбал уур амьсгалын өөрчлөлтийн улмаас Номхон далайн арлын орнуудад загасны нөөц эрс багассан, харин хойд өргөрөгийн орнууд болох Аляск, Гринланд, Норвеги, ОХУ зэрэгт загас нүүдэллэн очиж, загасны нөөц нэмэгдэх магадлалтай байна.

Ядуу буурай оронд амьдарч буй эмэгтэйчүүдэд ихэвчлэн байгалийн нөөцөд тулгуурласан амин зуулгын шинжтэй аж ахуй эрхлэх, ус авах ажлыг хийдэг тул байгаль орчны доройтлоос гарах сөрөг үр дагавруудад илүү их өргөнө. Эдгээрээс гадна маш олон уугуул иргэд байгалийн нөөц баялагт түшиглэн амьдарч байгаа бөгөөд дийлэнх нь уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг жижиг арлууд, хойд туйлын бүс нутгууд болон өндөрлөг газарт амьдарч байна. Хэдийгээр амьдралын уламжлалт хэв маяг, зан заншил нь байгаль орчны нөөцийг зохистой ашиглаж хамгаалж чадна гэж үздэг ч энэ уламжлал нь өнөөдөр алдагдаж, ард иргэд нь мөрдөхөө больжээ.

Уур амьсгалын өөрчлөлт нь тариаланчдын амьжиргаанд хэрхэн нөлөөлж байгаа нь тэд ямар ургамал, үр тариаг ямар бүс нутагт, ямар улиралд тарьж байгаатай ихээхэн холбоотой. Иймд тухайн орон нутгийн нөхцөл байдлыг сайтар харгалзсан, нарийвчилсан судалгааг явуулах шаардлагатай байна. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл нь тухайн өрхийн үйлдвэрлэл, хэрэглээний хэв маяг, байгалийн баялгийн нөөц, ядуурлын түвшин, байгаль орчны доройтлыг сааруулах чадвар зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан хоорондоо харилцан адилгүй илэрч болно. Гэхдээ, бүхлээр нь авч үзвэл уур амьсгалын өөрчлөлтөд хөдөө аж ахуйн усалгаатай ба усалгаагүй газар тариалан мөн нэрвэгдэж 2050 он гэхэд биофизикийн цэвэр нөлөөлөл сөрөг утгатай байх болно. Энэ төлөв байдал ХХИ-ийн түвшин доогуур улс оронд хамгийн хурц илэрнэ.

Хамаарлыг ойлгох нь

Хүн амын хамгийн эмзэг ядуу хэсэгт байгаль орчны доройтол илүү хурцаар нөлөөлөх талаар авч үзье. Байгаль орчны доройтолд илүү өртөх магадлалтай тэдгээр иргэд агаар, усны бохирдол, бохир ус, эрүүл ахуйн шаардлага хангаагүй нөхцөл зэрэг өөрсдийн эргэн тойронд учирч болох байгаль орчны эрсдэлийг бууруулах шаардлагатай болно. 2010 оны Хүний Хөгжлийн Илтгэлд шинээр нэвтрүүлж, эдүгээ 109 оронд ашиглаж буй Олон Хэмжүүрт Ядуурлын Индексийн (ОХЯИ) тусламжтайгаар дээр дурьдсан байгаль орчны доройтлын хэлбэрүүд хаана хамгийн ихээр тархаж байгааг судалж мэдэх боломжтой юм.

Олон улсын түвшин дэх байгаль орчин болон эрх тэгш байдлын хоорондын уялдаа холбоонд тулгуурлан бид дээрх хоёр үзүүлэлтийн харилцан хамаарлыг өрх болон, олон нийтийн түвшинд ямар байдгийг судалж үзлээ. Түүнчлэн бид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажил үүргийн хуваарь, эрх мэдлийн үзүүлэлтэд онцгой өөрчлөлт гаргасан улс орон, бүлэг хоршоодыг тодруулсан.


ОХЯИ-ээр ХХИ-ийн үндсэн үзүүлэлт болох эрүүл мэнд, боловсрол, амьжиргааны түвшинд гарсан ноцтой ухралтуудаас гадна олон хэмжүүрт ядууралд өртсөн хүн амын тоо, түүний тархалт, эрчимжилтийг давхар хэмжих боломжтой юм (Зураг 6). Энэ жил бид олон хэмжүүрт ядууралд өртсөн хүмүүсийн дунд нүүрлэж буй байгаль орчны доройтол болон түүний хамрах хүрээг өрхийн түвшинд судалснаар ОХЯИ-д шинэчлэлт хийж чадлаа.

Ядуурлын талаар явуулсан судалгаагаар өрхүүдийн эрчим хүчний хэрэглээ, цэвэр усны хангамж болон эрүүл ахуйн нөхцөлийг байгаль орчны доройтолтой уялдуулан тодорхойллоо. Байгаль орчны доройтлын улмаас хүний эрх асар ихээр зөрчигдөж байгаа бөгөөд байгаль орчны доройтлыг сааруулж, зогсоосноор хүмүүсийн амьжиргааны чадавхи, сонголт хийх боломж нь нэмэгдэж, хүний хөгжилд ахиц дэвшил гарах болно.

Хөгжиж буй орнуудад 10 хүн тутмын 6 нь байгаль орчны доройтлын ямар нэг хэлбэрт, 4 нь 2 болон түүнээс дээш хэлбэрт өртдөг байна. Эдгээр байгаль орчны доройтол нь нэн ялангуяа олон хэмжүүрт ядууралд өртсөн хүмүүст хурц тусах бөгөөд ийм 10 хүн тутмын 9 нь дээр дурьдсан байгаль орчны доройтлын аль нэг хэлбэрт заавал өртдөг. Ихэнх хүмүүс нэгээс олон төрлийн байгаль орчны доройтолд өртөж байна. Олон хэмжүүрт байгаль орчны доройтолд өртсөн 10 хүн тутмын 8 нь 2 болон түүнээс дээш төрөлд, харин ойролцоогоор гуравны нэг хэсэг нь буюу (29 хувь нь) дээр дурдсан байгаль орчны доройтлын бүх төрөлд нэрвэгдсэн байдаг байна.

ЗУРАГ 6

Олон хэмжүүрт ядуурлын индекс- байгаль орчны доройтолд өртөж буй хамгийн их үзүүлэлтэд анхаарлаа хандуулна үү



Байгаль орчны доройтол нь олон хэмжүүрт ядууралд тэнцүү бусаар нөлөө үзүүлж байгаа бөгөөд түүний 20 хувийг эзэлж байгаа нь байгаль орчны доройтлын хэлбэрүүдийн тус индексэд эзэлж буй 17 хувиас дээгүүр байна. Ихэнх хөгжиж буй оронд эрчим хүчний хангамж хязгаарлагдмал байдал хамгийн өндөр байгаа бол Арабын улс орнуудад цэвэр усны хомсдол үндсэн асуудал болж байна.

Байгаль орчны доройтлын талаар илүү зөв ойлголттой болох үүднээс бид ядуурлын түвшнээр дүн шинжилгээ хийлээ. Олон хэмжүүрт ядууралд нэрвэгдэхийн хажуугаар байгаль орчны доройтлын аль нэг хэлбэрт өртсөн хүмүүсийн эзлэх хувь хэмжээг байгаль орчны доройтлын бүх хэлбэрт өртсөн ядуу иргэдтэй харьцуулан жагсаахад байгаль орчны доройтолд өртсөн хүн амын тоо өсөхөд олон хэмжүүрт ядуурал дагаад өсч байгаа бөгөөд ингэхдээ харилцан адилгүй байна гэсэн дүгнэлтэд хүрлээ. Хүснэгт 2-т олон хэмжүүрт ядууралд өртсөн мөртлөө (зүүн талын баганыг харна уу) байгаль орчны доройтолд хамгийн бага өртсөн 10 орныг танилцуулж байна. Байгаль орчны доройтлын нэг хэлбэрт өртсөн, олон хэмжүүрт ядуурлын түвшнээрээ хамгийн доогуур улс орнуудын дийлэнх нь Араб, Латин Америк болон Карибын бүс нутгуудад байна. (Шилдэг 10 улсын 7 нь дээрх бүсэд харъяалагддаг.)

ХҮСНЭГТ 2

Олон хэмжүүрт ядуурлын индексээр тооцоход байгаль орчны доройтолд хамгийн бага өртсөн 10 орон

ОХЯИ-ээр тооцоход байгаль орчны доройтол доод тал нь нэг төрөлд өртсөн орон	ОХЯИ-ээр тооцоход байгаль орчны доройтлын бүх 3 төрөлд өртсөн байдлаар
Бразил	Бангладеш
Гайана	Пакистан
Жибути	Гамби
Йемен	Непал
Ирак	Энэтхэг
Марокко	Бутан
Пакистан	Жибути
Сенегал	Бразил
Колумб	Марокко
Ангол	Гайана

Тэмдэглэл: Тодруулж бичсэн орнууд аль алинд нь хамаарагдана.

Эх сурвалж: ОХЯИ-н тоо мэдээнд үндэслэн ХХИГ тооцов.

Байгаль орчны доройтол нь хэд хэдэн чиглэлээр хүний амьдралд сөргөөр нөлөөлж байна. Тэрээр хүн амын орлого, амьжиргаанд нөлөөлөөд зогсохгүй эрүүл мэнд, боловсрол болон сайн сайхан амьдралын бусад үзүүлэлтийг доройтуулдаг.

Харин байгаль орчны бүх доройтолд өртсөн, олон хэмжээст ядуурлын түвшингээр доогуурт жагсаж байгаа 10 орны 5 нь Өмнөд Азид хамаардаг байна. (Хүснэгт 2-ын баруун талын баганыг харна уу) Өмнөд Азийн олон орон байгаль орчны зарим доройтлоо бууруулж чадсан бөгөөд тэдгээрээс нэн ялангуяа цэвэр усны хангамжийн үзүүлэлтээр ахиц дэвшил гарсан боловч доройтлын бусад хоёр хэлбэр нь буураагүй байна. Харин дээр дурьдсан шилдэг 5 орон байгаль орчны доройтлыг үлэмж хэмжээгээр бууруулаад зогсохгүй түүний тархац, эрчмийг сааруулж чаджээ.

Байгаль орчны эдгээр үзүүлэлтээр түүний учруулж болох бүх эрсдэлийг тухайлбал үер усны гамшигт нэрвэгдэгсэд зэргийг тодорхойлох боломжгүй юм. Түүнчлэн ядуу хүн ам байгаль орчны гэнэтийн аюул болон доройтолд нэрвэгдэх магадлал маш өндөр юм.

Бид энэ магадлалыг ОХЯИ болон уур амьсгалын өөрчлөлтийн улмаас учрах дарамт хоорондын хамааралтай уялдуулан гүнзгийрүүлэн судалж байна. 15 орны 130 засаг захиргааны нутаг дэвсгэрийг хамруулан бид бүс нутгуудийн ОХЯИ-үүдийг хур тунадас болон температурт гарсан өөрчлөлтөөр нь харьцуулан тооцлоо. Энэ харьцуулалтаас харахад хамгийн ядуу бүс нутгуудад агаарын температур нэмэгдсэн боловч чийгшил эсхүл хуурайшил нэмэгдээгүй байна. Энэ нь орлогын ядууралд уур амьсгалын өөрчлөлт хэрхэн нөлөөлж буй талаар хийсэн судалгааны дүнтэй нийцэж байна.

Байгаль орчны доройтол хүний хөгжлийн зарим үзүүлэлтэд сөргөөр нөлөөлөх нь

Байгаль орчны доройтол нь хэд хэдэн чиглэлээр хүний чадавхид сөргөөр нөлөөлөн, боогдуулж байна. Тэрээр хүн амын орлого, амьжиргаанд нөлөөлөөд зогсохгүй эрүүл мэнд, боловсрол болон сайн сайхан амьдралын бусад үзүүлэлтийг доройтуулдаг.

Байгаль орчин, эрүүл мэнд доройтох нь

Агаар, усны бохирдол, эрүүл ахуйн таагүй нөхцөл зэргээс улбаалсан өвчлөл ядуу орнуудад, нэн ялангуяа ядуу хүн амын дунд өргөн тархацтай байна. ХХИ-ийн түвшин доогуур улс орнуудад агаарын бохирдлоос шалтгаалах хүн амын нас баралтын түвшин ХХИ-ийн түвшин дунд болон дээгүүр орнуудынхаас даруй 11 дахин өндөр байна.


ХХИ-ийн түвшин доогуур, дунд, өндөр орнуудын ядуу хүн амын эрүүл мэндэд агаарын бохирдол мөн л сөрөг нөлөө үзүүлдэг. ХХИ-ийн түвшин доогуур улсын 10 хүн тутмын 6 нь цэвэр усны хангамжаар, 4 нь эрүүл ахуйн нөхцөл хангагдсан ариун цэврийн байгууламжаар дутагдаж байгаа нь өвчлөл болон хоол тэжээлийн дутагдал бий болоход нөлөөлж байна. Уур амьсгалын өөрчлөлт нь нэг талаараа хумхаа, чичрэг зэрэг халуун орны өвчний тархалтыг нэмэгдүүлж, нөгөө талаас ургац их хэмжээгээр буурахад хүргэж байгаа нь тэгш бус байдлыг улам даамжруулах үр дагавартай.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас явуулдаг Олон Улсын Өвчлөлийн Түвшний судалгаагаар өвчлөл үүсгэх 10 үндсэн шалтгаанд бохир ус, шаардлага хангаагүй ахуйн болон ариун цэврийн нөхцөл зэрэг орчны хүчин зүйлс багтаж байна. Суулгалт, амьсгалын замын халдварт өвчин зэрэг орчны доройтлоос үүдэн гардаг өвчнөөр жил бүр 5 хүртэлх насны 3 сая хүүхэд эндэж байгаа нь Австрали, Белги, Нидерланд, Португал, Швейцари Улсын 5 хүртэлх насны хүүхдийн нийт тооноос давж байна.

Байгаль орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлт нь бидний хүрээлэн буй болон нийгмийн орчин, мэдлэг чадвар, өмч хөрөнгө, дадал зуршилд сөрөг нөлөө үзүүлдэг. Ядуу дорой байдлын хэмжүүрүүд нь хоорондоо харилцан уялдаатай бөгөөд тэдгээр хэмжүүрүүдийг хамтад нь авч үзэхэд: ялангуяа, цэвэр усны хангамж болон эрүүл ахуйн нөхцөл хангалтгүй байгаа газарт хүний эрүүл мэнд хамгийн эрсдэлтэй байна. Байгаль орчны доройтлоос үүдэлтэй нас баралтын түвшин хамгийн өндөрт тооцогддог 10 орны 6 нь Нигери, Мали, Ангол зэрэг ОХЯИ-н түвшнээр хамгийн өндөр 10 улс орон орсон байна (Зураг 7).

ЗУРАГ 7

ОХЯИ түвшин өндөртэй улс орны байгаль орчны доройтлын эрсдэлээс үүдэлтэй хүн амын нас баралтын түвшин



Тэмдэглэл: ХХИ түвшин өндөр улсуудыг хамруулаагүй болно. Судалгаа хийсэн жилүүд нь улс орнуудад харилцан адилгүй. Эх тайлангийн статистикийн хүснэгт 5-г харна уу.

Эх сурвалж: ДЭМБ, R.Bos, F.Gore, J.Bartam, 2008. Цэвэр ус: Эрүүл амьдрал: эрүүл мэндийг хамгаалах оролцооны зардал, ашиг, тогтвортой байдал, Женев.

Бололцоо багатай хүүхдүүд, ялангуяа охидын боловсрол хоцрогдох байдал

Дэлхийн олон орон бүх нийтийг хамарсан багаанхан шатны боловсрол олгох зорилт тавиад ажиллаж байгаа ч бүрэн амжилтанд хүрч чадаагүй байна. ХХИ-ийн түвшин доогуур улс оронд анхан шатны боловсрол эзэмших насны 10 хүүхэд тутмын 3 нь сургуульд огт хамрагддаггүй, үлдсэн хэсэг нь сургуульд хамрагддаг боловч байгаль орчны доройтлын хэд хэдэн хүчин зүйлийн улмаас сурах явцдаа маш олон саад бэрхшээлтэй тулгардаг байна. Тухайлбал эрчим хүчний хомсдол нь тэднийг сургуульд сурахад шууд болон шууд бус замаар нөлөөлдөг. Эрчим хүчний хомсдолыг арилгаснаар сургуулийн байрны гэрэлтүүлэг сайжирч, хүүхдүүдийн хичээл хийх цагийг нэмэгдүүлэхээс гадна орчин үеийн цахилгаан зуух ашигласнаар ус, түлээ бэлтгэх цагийг хэмнэх боломжтой. Гэвч энэ боломж бүрдээгүйн улмаас бага насны хүүхдүүд боловсрол эзэмших болон сургуульд бүрэн хамрагдахад сөргөөр нөлөөлж байна. Охид сурахын хажуугаар гэрийнхээ ус, түлээ бэлтгэх ажлыг давхар хийдэг тул байгаль орчны доройтолд илүүтэй өртдөг. Цэвэр усны хангамжийг нэмэгдүүлж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах нь охидын боловсрол эзэмшилтэд маш тустай бөгөөд тэдний эрүүл мэндэд эерэгээр нөлөөлж, ажил хийхэд зарцуулж буй цагийг нь хэмнэх, чөлөөт цагаа өөртөө зарцуулах боломжтой болно.

Байгаль орчны доройтлын бусад сөрөг нөлөөлөл

Өрх айл, бүс нутаг, дэлхийн зэрэг бүхий л түвшинд үүсэх байгаль орчны доройтол нь хүмүүсийн сонголтыг хязгаарлаж, байгалийн нөөц баялагт түшиглэн амьдардаг хүн амын амьдрах нөхцөлийг улам доройтуулдаг, өөрөөр хэлбэл ийм хүмүүс өмнө нь олдог байсантай ижил хэмжээний орлогыг олохын тулд илүү их хөдөлмөрлөх эсвэл байгаль орчны доройтолд өртсөн газар нутгаасаа нүүдэллэн өөр газарт суурьшихаас өөр сонголтгүй болдог.

Байгалийн нөөц баялагт түшиглэсэн өнөөгийн амьжиргааны арга хэрэгслүүд нь цаг маш ихээр зарцуулахыг шаарддаг. Ялангуяа орчин үеийн цахилгаан зуух болон цэвэр усны хангамж хомсдолтой өрхүүд үүнд асар их цагийг үргүй зарцуулахад хүрдэг. Цаг ашиглалтын судалгаанд дээрх чиглэлээр хүйсийн тэгш бус байдлын талыг тусган шинжлэхэд ус, түлээ бэлтгэх гэрийн ажилд охид эмэгтэйчүүд эрчүүдээс илүү их цаг зарцуулдаг бөгөөд энэ ажилд ингэж их цаг зарцуулж байгаа тул үр ашигтай ажил эрхлэх боломж хомс байх аж.

2009 оны Хүний Хөгжлийн Илтгэлийн тодорхойлноос харахад хүмүүст амьдрах газраа өөрсдөө сонгох эрхийг олгосноор тэдний эрх чөлөөг нэмэгдүүлэх, илүү үр өгөөжтэй, сайн сайхан амьдрахад чухал хөшүүрэг болно. Гэхдээ хүн амын шилжих хөдөлгөөнийг хуулийн зарим заалтаар

хязгаарлагддаг. Хичнээн хүн зөврөн байгаль орчны доройтлоос шалтгаалан уугуул нутгаасаа нүүж, өөр газар шилжин суурьших болсныг тооцоолоход хүндрэлтэй байгаа нь ядуурал зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалан шилжин суурьсан байж болзошгүй байгаатай холбоотой. Гэсэн хэдий ч ийм судалгаа хийж чадсан ба маш олон хүн байгаль орчны доройтлоос улбаалан шилжин нүүж байна.

Байгаль орчны доройтол нь улам бүр нэмэгдсээр буй зөрчил мөргөлдөөнтэй хамааралтай. Гэхдээ энэ хамаарал шууд илэрдэггүй, улс төр болон тухайн газрын нөхцөл байдал нь дангаараа эсхүл нутаг усаараа эсхүл бүхэл нийгмээрээ байгаль орчны доройтолд эмзэг өртөмтгий байдалд ороход нөлөөлдөг.

Цаг агаарын гэнэтийн үзэгдлийн сөрөг нөлөө

Байгаль орчны доройтол нь гэнэтийн аюул, гамшиг тохиолдох магадлалыг нэмэгдүүлж байна. Бидний хийсэн дүн шинжилгээнээс харахад ХХИ-ийн түвшин дундаж улс орнуудад цаг агаарын гэнэтийн үзэгдэл буюу гамшигт өртсөн хүн амын тоо 10 хувиар нэмэгдэж, хүн амын амьжиргаа болон орлогын эх үүсвэрийг эрс доройтуулахаас гадна ХХИ-ийн түвшин 2 хувиар буурчээ.

Аюул гамшигийн сөрөг үр дагавар нь эрэгтэй эмэгтэй хүмүүс, тэдний нас, амьдарч буй улс орноос хамааран харилцан адилгүй тусдаг байна. Ялангуяа буурай хөгжилтэй орнуудад үер усны гамшиг, хүчтэй салхи, шуурга, хөрсний гулсалт зэрэг байгалийн гамшигийн улмаас хүүхэд эмэгтэйчүүд болон хөгшчүүд илүүтэй бэртэж гэмтэн, эндэж байна. Байгалийн гамшигт нэрвэгдсэн хүмүүсийг хүйсийн задаргаагаар тооцоход эмэгтэйчүүд байгалийн баялаг ашиглах боломж, чадавхи сул байгаагаас үүдэн байгаль орчны доройтолд улам эмзэг өртөмтгий болж байна.

Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс болоод хүүхдүүд хоол тэжээлийн дутагдалд орж, сургууль завсарддаг. Хэд хэдэн хөгжиж буй орны жишээнээс харахад гамшигт нэрвэгдсэний дараа айл өрхүүд түр зуурын санхүүгийн хямралд орж, хүүхдүүдээ сургууль завсардуулах явдал их гардаг. Тодруулбал, байгалийн гамшигт хэдий хэмжээгээр нэрвэгдэх, түүнийг хор хохирол багатай даван туулах чадвар нь хэд хэдэн хүчин зүйлээс хамаарна. Үүнд: байгалийн ямар гамшигт нэрвэгдсэн, тухайн өрхийн нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, нийгмийн хөрөнгө болон бусдаас дэмжлэг туслалцаа авах боломжоос гадна тухайн улс орны засгийн газрын зүгээс явуулах аврах, сэргээн босгох үйл ажиллагаа аль зэрэг тэгш хүртээмжтэй болон үр өгөөжтэй байгаагаас хамаарна.

Бидний хийсэн дүн шинжилгээнээс харахад ХХИ-ийн түвшин дундаж улс орнуудад цаг агаарын огцом үзэгдэл буюу гамшигт өртсөн хүн амын тоо 10 хувиар нэмэгдэж, хүн амын амьжиргаа болон орлогын эх үүсвэрийг эрс дордуулахаас гадна ХХИ-ийн түвшин 2 хувиар буурчээ.

Эрх мэдэл – нөхөн үржихүйн болон улс төрийн эрх мэдэл дэх тэнцвэргүй байдал

Зарим оронд хүйсийн үүрэг хариуцлага, эрх мэдэлд өөрчлөлт гарч, энэ нь байгаль орчны тогтвортой хөгжил, тэгш байдлыг нэмэгдүүлж, хүний хөгжлийн түвшинг урагшлуулахад эерэг нөлөө үзүүлж байна.

Жендэрийн тэгш бус байдал

Энэ жил 145 орны Жендэрийн тэгш бус байдлын индексийг шинэчлэн тооцсоноос харахад нөхөн үржихүйн эрүүл мэнд доройтоход жендэрийн тэгш бус байдал нэмэгдэж байна. Нийт хүн амд чиглэсэн нөхөн үржихүйн үр дүнтэй бодлого хэрэгжүүлж буй орнуудад эмэгтэйчүүд төлөвлөснөөсөө олон хүүхэд гаргааа зогсоон, үүний дүнд эх, үрсийн эрүүл мэнд сайжрахын зэрэгцээ хүлэмжийн хийн ялгаруулалт ч буурах хандлага ажиглагдлаа.

Куба, Мавритани, Тайланд, Тунис зэрэг оронд нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ дээшилж, эм тарианы хангамж нэмэгдсэнээр нэг эмэгтэйд 2-оос доош тооны хүүхэд ногдох хүртэл түвшинд төрөлт буурсан. Гэсэн хэдий ч олон улс оронд нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах шаардлагатай байна. Хэрвээ бүх эмэгтэй хүн нөхөн үржихүйн өргөн сонголт хийх боломжтой бол хүн амын хяналтгүй өсөлт багасч, энэ нь хүлэмжийн хийн ялгаруулалтыг одоогийн түвшнээс бууруулах болно. 2050 он гэхэд гэр бүл төлөвлөлтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чадвал хүлэмжийн хийн ялгарч буй хэмжээг одоогийнхоос 17 хувиар бууруулах боломжтой юм.

Жендэрийн Тэгш Бус Байдлын Индекс нь улс төрийн шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн оролцоог мөн тооцож гаргадаг. Тооцооноос харахад ялангуяа Африкийн Сахарын цөлөөс урагш орших бүс, Өмнөд Ази, Арабын орнуудад цөөн тооны эмэгтэйчүүд улс төрийн шийдвэр гаргахад оролцож байна. Эмэгтэйчүүд байгалийн баялаг ашиглан амьжиргаагаа залгуулах ачааллын хамгийн хүндийг үүрдэг тул хүрээлэн буй орчны бохирдолд, тухайлбал агаарын бохирдолд хамгийн түрүүнд өртдөг, түүнчлэн байгалийн баялаг ашиглах талаар гарч буй шийдвэр тэдэнд хамгийн түрүүнд нөлөөлдөг.

Саяхан явуулсан судалгаагаар хичнээн эмэгтэй улс төрийн шийдвэр гаргахад оролцож буйг мэдэх төдийгүй яаж, аль зэрэг оролцож байгааг мэдэх нь чухал болжээ. Учир нь эмэгтэйчүүд байгаль орчны асуудалд илүү санаа тавьдаг, байгаль орчны бодлого хөтөлбөрийг дэмжин, түүнийг хамгаалахад уриалж буй удирдагч нарыг сонгох хандлагатай байдаг тул улс төр, төрийн бус байгууллагад эмэгтэйчүүдийг идэвхийлэн оролцуулах нь байгаль орчноо хамгаалан байгалийн баялгийг зохистой ашиглах, улмаар Мянганы Хөгжлийн Зорилтуудыг бүрэн хэрэгжүүлэхэд ихээхэн түлхэц болох юм.

Бидний энэ дүгнэлт цоо шинэ санаанд үндэслээгүй. Гагцхүү эмэгтэйчүүдийн эрх чөлөөг дэмжин нэмэгдүүлснээр бид юу хожиж, бидэнд ямар сайн үр дагавар гарч болохыг нотлон харуулах зорилгоор дээрх дүгнэлтийг давтан санууллаа. Шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийг оролцуулах нь эрх тэгш байдал, байгаль орчны доройтол зэрэг асуудлыг шийдвэрлэхэд асар чухал ач холбогдолтой.

Эрх мэдлийн тэгш бус байдал

2010 оны Хүний хөгжлийн илтгэлд тодорхойлсны дагуу, эрх мэдэл гэдэг нь улсын түвшинд албан ёсны үйл ажиллагааны дэс дараа, ардчилал, орон нутгийн түвшинд оролцооны арга барилыг хамарсан өргөн хүрээний ойлголт юм. Улсын болон орон нутгийн түвшинд улс төрийн тэгш эрхийг бүрэлдүүлснээр байгаль орчны тогтвортой хөгжлийг бий болгодог. Эрх мэдлийг тэнцвэржүүлэх нь агуулгын хувьд чухал ач холбогдолтой байхын сацуу олон тооны судалгаанаас харахад ардчилал нь сонгогчдын өмнө хүлээх үүрэг хариуцлагыг өндөржүүлж, хүн амын эрх чөлөөг нэмэгдүүлэхэд чиглэдэг. Гэхдээ аливаа улс оронд (үүнд ардчиллын тогтолцоо бүрэлдсэн улс орон бас багтана) байгаль орчны доройтолд хамгийн их өртсөн хүн ам ядуурч, доройтон эрх мэдэлгүй болдог бөгөөд улмаар үндсэн бодлогод ядуу, эрх мэдэлгүй хүмүүсийн үзэл бодол, ашиг сонирхол тусдаггүй.

Дүн шинжилгээнээс үзэхэд улс төрийн байгууллагуудын оролцоотойгоор эрх мэдлийн тэгш бус байдал үүсч, байгаль орчны тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна. Энэ нь байгаль орчны доройтол хүн амын ядуу хэсэг болон нийгмийн эмзэг дорой бүлэгт илүү хүндээр тусч байгаа гэсэн үг юм. Тус илтгэлийг боловсруулах явцад 100 гаруй орныг хамруулан хийсэн шинэчилсэн судалгаагаар эрх мэдлийн тэгш хувиарилалттай байгаа орнуудад байгаль орчны доройтолтой тэмцэж, тодорхой үр дүнд хүрчээ. Тодруулбал, цэвэр усны хангамж сайжирч, газрын доройтол багасан, агаар, усны бохирдлоос үүдэлтэй хүн амын эндэгдэл буурч байгаа зэрэг эерэг үр дүн гарч байна.

Байгаль орчин, эрх тэгш байдал, хүний хөгжлийг хамарсан цогц стратеги

Өнөөдөр бидэнд нүүрлэж буй аюул гамшгаас сэргийлж, сайн сайхан амьдралыг цогцлоох үүднээс засгийн газар, иргэний нийгэм, хувийн хэвшил, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагууд хамтран байгаль орчны тогтвортой хөгжил, тэгш байдал, хүний хөгжил гэсэн гурван үзүүлэлтийг цогцоор нь авч үзсэн стратеги төлөвлөгөө боловсруулсан юм. Энэхүү стратеги төлөвлөгөө нь дээрх гурван үзүүлэлтийг тэнцвэртэйгээр, бүгд хожиж зарчим дээр үндэслэж байгаа билээ. Гарсан шийдлүүд тухайн нөхцөл байдалд тохирсон байх ёстой бөгөөд бодлого боловсруулахдаа тухайн орны чадавхи болон боловсруулан гаргасан

2050 он гэхэд гэр бүл төлөвлөлтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чадвал хүлэмжийн хийн ялгарч буй хэмжээг одоогийнхоос 17 хувиар багасгах юм.

шийдлүүдийг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг нь харгалзах хэрэгтэй. Бид орон нутгийн түвшинд оролцооны аргад суурилсан институцийг, харин улсын түвшинд оновчтой шинэлэг шийдлүүд болон бодлого, зохион байгуулалтын хүрээг тэлэн, дэлгэрүүлэх хэрэгтэй байна.

Бодлого нь өргөн хүрээний асуудлуудыг хамарна. Энэхүү илтгэлээр бодлогын бүх хүрээний асуудлуудыг хөндөж чадахгүй ч нийгэм, эдийн засаг, байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхдээ бүгд хожих зарчимд тулгуурласан стратеги төлөвлөгөөг тодорхойлох боломжтой болох юм. Үүнд байгаль орчин, тэгш байдал, хүний хөгжил гэсэн гурван үзүүлэлтийг тэнцвэртэйгээр, бие биетэй нь уялдуулж, цогц байдлаар шийдвэрлэхэд тэргүүлэх ач холбогдол өгснөөрөө энэ илтгэлийн бусдаас ялгагдах давуу тал болж байна. Хэлэлцүүлэг, үйл ажиллагааг өрнүүлэхэд дөхөм болох үүднээс бид дээрх стратеги төлөвлөгөөг үр ашигтай хэрэгжүүлсэн бодит жишээг илтгэлд орууллаа. Эдгээр бодит жишээний нэг болох орчин үеийн эрчим хүчний хэрэглээний туршлагыг доор танилцуулж байна.

Орчин үеийн эрчим хүчний хангамж

Эрчим хүчний хангамж нь хүний хөгжлийн үндсэн асуудал боловч ойролцоогоор 1,5 тэрбум буюу дэлхийн нийт хүн амын тавны нэг нь эрчим хүчинд холбогдоогүй байна. Олон хэмжүүрт ядууралд өртсөн хүмүүс байгаль орчны доройтолд илүү нэрвэгдэж, 3 хүн тутмын нэг нь эрчим хүчинд холбогдоогүй байдаг байна.

Эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх болон CO₂ нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаралтын хооронд сонголт хийх шаардлага бий юу? Ингэх шаардлага байхгүй. Бид ийм хандлагыг буруу гэж үзэж байна. Байгаль орчинд их хэмжээний дарамт учруулалгүйгээр эрчим хүчний хангамжийг сайжруулах хэд хэдэн арга бий. Үүнд:

- Төвлөрсөн бус эрчим хүчний эх үүсвэрүүд ядуу өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангаж болно. Эдгээр эх үүсвэр зардал багатай төдийгүй уур амьсгалын өөрчлөлтөд маш бага нөлөө үзүүлдэг, өөрөөр хэлбэл байгаль орчинд хал багатай гэсэн үг.
- Дээр дурьдсан цогц стратеги бодлогод үндэслэн бүх нийтийг орчин үеийн эрчим хүчний эх үүсвэрт холбох юм бол нүүрстөрөгчийн давхар ислийн хэмжээг ердөө 0,8 хувиар нэмэгдүүлэх юм.

2010 оны түвшинд дэлхийн сэргээгдэх эрчим хүчний түвшин олон улсын эрчим хүчний үйлдвэрлэлийн 25 хувьд хүрч, эрчим хүчний хэрэгцээний 18-аас доошгүй хувийг хангах болсноор дэлхийн эрчим хүчний хангамжид өөрчлөлт гарах боломж бүрдэж байна.

Байгаль орчны доройтлоос сэргийлэх нь

Нөхөн үржихүйн сонголт хийх бололцоог өргөжүүлэхээс эхлээд хамтыг оролцоо бүхий ойн менежментийг идэвхжүүлэх, байгалийн гамшигтай тэмцэх үйл ажиллагааг дэмжих зэрэг байгаль орчны доройтлоос сэргийлэх маш олон арга хэрэгсэл, үйл ажиллагаа бий.

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах замаар эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрхийг нэмэгдүүлэх нь тэгш эрхийг бий болгох урьдчилсан нөхцөл болоод зогсохгүй байгаль орчны доройтлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлэх юм. Нөхөн үржихүйн чиглэлээр томоохон ахиц, дэвшил гаргах боломжууд байна. Хэд хэдэн улсын жишээнээс харахад өнөөгийн эрүүл мэндийн дэд бүтэцдээ суурилан нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг хамгийн бага өртгөөр үзүүлэх, энэ үйл ажиллагаанд олон нийтийг хамруулах зэрэг үр дүнтэй аргуудыг ашигласан байна. Тухайлбал Бангладешт 1975 онд нэг эмэгтэйд 6,6 төрөлт ногддог байсан бол 2009 онд 2,4 болж буурчээ. Тус орны Засгийн газар үзэл суртлын арга хэмжээ авахаас гадна жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх эм, хэрэгслийн хангамжийг сайжруулах чиглэлээр төрийн зүгээс татаас олгож, шашны тэргүүн, багш сурган хүмүүжүүлэгч нар болон төрийн бус байгууллагуудын эрэгтэй, эмэгтэй төлөөлөгчдийг оролцуулан хэлэлцүүлэг явуулах замаар төрөлтийн талаарх нийгмийн үзэл сурталд нөлөө үзүүлж, төрөлтийг бууруулж чадсан юм.

Хамтын оролцооны ойн менежмент нь орон нутагт байгаль орчны доройтлыг бууруулахаас гадна нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаралтыг бууруулахад чухал ач холбогдолтой боловч энэ үйл ажиллагаанд ядуу дорой хүн ам, нийгмийн бүлгүүд хамрагдахгүй байх эрсдэл байсаар байна. Энэ эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд ойн менежментийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцад бүх нийтийг, нэн ялангуяа эмэгтэйчүүд, ядуу иргэд болон нийгмийн бүлгүүд, байгалийн нөөц баялаг буюу орлогын эх үүсвэр нь ой модноос хамааралтай хүн амын бүх хэсгийг дээрх үйл ажиллагаанд татан оролцуулах хэрэгтэй.

Байгалийн гамшгаас урьчилан сэргийлэх, тэгш байдлыг нэмэгдүүлэх, улмаар нийгмийн хамгааллын шинэлэг тогтолцоог бий болгосноор байгаль орчны доройтлын улмаас урган гарч буй сөрөг нөлөөллүүдийг бууруулах боломжтой. Олон нийтэд түшиглэн эрсдэлийн зураглал гаргах, дахин сэргээгдсэн байшин барилга, бусад өмч хөрөнгийг оновчтой хуваарилах зэрэг нь гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаануудын нэг хэлбэр юм. Байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах ажлыг төвлөрсөн бус аргаар хэрэгжүүлэх туршлагауд гарч байна. Төлөвлөлт, шийдвэр гаргахад олон нийтийн, ялангуяа эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй. Орон нутгийн иргэдийн оролцоотойгоор өнөөгийн тэгш бус байдлыг бууруулах арга хэлбэрүүдийг шинэчлэн боловсронгуй болгож чадна.

Байгаль орчинд их хэмжээний дарамт учруулалгүйгээр эрчим хүчний хангамжийг сайжруулах хэд хэдэн үр дүнтэй арга бий.

Хөгжлийн загварыг эргэн нягталж, өөрчлөлт хийх нь

Хүн ам, нийгмийн анги бүлэг, улс орнуудад оршсоор байгаа тэгш бус байдал нь байгаль орчны доройтлыг даамжруулж байгаа тул хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийг нягтлан харж, боловсронгуй болгох хэрэгтэй байна. Бидэнд байгаль орчны доройтлыг сааруулах боломж бий. Дэлхийн хэд хэдэн улс оронд шинэлэг бодлого, санаачлагыг хэрэгжүүлснээр дэвшил гаргаж чадах таатай нөхцөл бүрдээд байна. Тогтвортой хөгжлийн (Рио+20) талаарх НҮБ-ын Хурлын өмнө, мөн 2015 оноос хойшхи шинэ хөгжлийн эрин эхлэхийн өмнө бид энэ чиглэлээр шинэ санаа, санаачлага гарган зоримог алхмуудыг хийх хэрэгтэй. Энэ жилийн илтгэлд байгаль орчны тогтвортой хөгжил болон тэгш байдлыг хүний хөгжлийн үзүүлэлттэй хамт, цогц хэлбэрээр авч үзсэнээрээ өмнөх жилүүдийн илтгэлээс онцлог, давуу болж чадсан юм.

Энэхүү илтгэлээр дараах дүгнэлтэнд хүрч, гурван зүйлийг онцоллоо. **Нэгд**, орон нутгийн түвшинд - бодлого хөтөлбөрийн анхан шатны боловсруулалтад иргэдийн тэгш оролцоог бүрдүүлэх, **хоёрт**, улсын түвшинд - улс төр, хуулийн хүрээний тэгш эрхийг бий болгох, ингэснээрээ хүний хөгжилтэй холбоотой бүх асуудалд эерэг нөлөө үзүүлэх, **гуравт** - олон улсын түвшинд - их хэмжээний нөөц баялгийг байгаль орчны доройтлыг бууруулахад зориулан, эрх тэгш байдлыг нэмэгдүүлэх, эдийн засгийн хувьд ядуу улс орон, нийгмийн бүлгүүдэд санхүүгийн туслалцаа үзүүлэх хэрэгтэйг тэмдэглэв.

Ногоон эдийн засгийн бодлогод эрх тэгш байдлын үзэл санааг нэгтгэх нь

2011 оны Хүний Хөгжлийн Илтгэлийн үндсэн сэдэв нь байгаль орчинтой холбоотой бүхий л бодлого эрх тэгш байдлын үзэл санааг тусгах явдал юм. Байгаль орчны үнэлгээ хийх уламжлалт аргууд нь учир дутагдалтай байна. Тэдгээр аргаар байгаль орчны үзүүлэлтүүдийг, тухайлбал, хорт хийн ялгарлын ирээдүйн төлөв байдлыг тодорхойлж болох ч нийгмийн өөр өөр бүлэг, улс орнуудад ямар цар хүрээтэй, яаж тусахыг тодорхойлоход хүндрэлтэй. Байгаль орчны доройтол нийгмийн ялгаатай бүлгүүдэд хэрхэн тусахыг тодорхойлж чадсан ч энэ нь бусад хүчин зүйлийг орхигдуулан зөвхөн орлогын үзүүлэлтийг хамрана. Ногоон эдийн засгийн бодлогын зорилтуудад тэгш байдал болон оролцооны аргын ач холбогдлын талаар тусгасан бөгөөд бид бодлогын зорилтуудыг баяжуулахад анхаарах ёстой. Бүх оролцогч тал, байгууллагуудын төлөөллийг оролцуулан бодлого боловсруулахад тэгш байдлын асуудлыг тусгахдаа дараах хүчин зүйлсийг харгалзан үзэх хэрэгтэй. Үүнд:

- ОХЯИ-ийн тодорхой хэдэн аргуудаар сайн сайхан амьдралын орлогын бус хүчин зүйлийн хэмжүүр
- Бодлогын шууд болон шууд бус нөлөөлөл

- Байгаль орчны доройтолд өртсөн хүмүүст олгох нөхөн төлбөр
- Цаг агаарын эрс тэс үзэгдэл нь байгалийн гамшиг болон хувирах магадлал.

Бодлогын байгаль орчны үр дагавар болон нийгмийн янз бүрийн бүлэгт нөлөөлөх нөлөөллийг эрт үнэлж дүгнэх тусмаа сайн байна.

Цэвэр, аюулгүй орчинд амьдрах эрх

Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжинд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн талаар тусгахын сацуу иргэд эрхээ эдлэх боломжийг мөн тусгах ёстой. 120 орны үндсэн хуулинд байгаль орчны хэм хэмжээний талаар тусгасан ба бусад орон байгаль орчны эрхийн талаар тусгаа хууль тогтоомж гаргаагүй ч хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн талаар тусгасан хуулийн заалттай байдаг байна.

Үндсэн хуулинд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг тунхагласнаараа тэгш байдлыг хуульчлан тогтоосон бөгөөд ингэхдээ байгалийн баялаг ашиглах эрхийг хязгаарлаагүй юм. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хуульчилснаар Засгийн газраас дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх, байгалийн баялгийн үр шимийн зохистой хувиарлалтад түлхэц болох юм.

Ийнхүү эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрөхийн сацуу таатай орчин нөхцлийг бүрдүүлж шударга ёс, бие даасан шүүх засаглал зэрэг олон нийтийн байгууллагуудыг чадавхижуулж, Засгийн газар, томоохон аж ахуйн нэгж, корпорациудаас мэдээлэл авах эрхийг нь нэмэгдүүлэхэд нэн тустай юм. Олон улсын байгууллагууд мөн байгаль орчны талаар аливаа мэдээлэл авах эрх олгох нь тун чухал ач холбогдолтой болно.

Оролцоо болон үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх

2010 оны Хүний Хөгжлийн Илтгэлд тодорхойлсноор хэвлэл мэдээлэл болон хүний эрх чөлөөг нэмэгдүүлэх нь хүний хөгжлийн үндсэн асуудал юм. Эрх мэдлийн тэгш бус байдал нь байгаль орчны доройтолд нөлөөлж, түүнийг даамжрахад хүргэж байна. Гэхдээ эрх мэдлийн тэгш бус байдлыг бууруулж, холбогдох талуудыг чадавхижуулж, эрх мэдлийг олгосноор байгаль орчны доройтлыг бууруулахад чухал ач холбогдолтой.

Ардчилал чухал гэдгийг зөвхөн хүлээн зөвшөөрөх төдийгүй олон нийтийн байгууллагуудын үүрэг хариуцлагыг өндөржүүлж, үйл ажиллагааг нь оролцооны аргад суурилан бүх нийтийг хамруулдаг болгох шаардлага байна. Үүнд нийгмийн бүх анги давхарга, ялангуяа эмэгтэйчүүдийг хамруулах хэрэгтэй бөгөөд ингэснээр иргэний нийгмийг чадавхижуулах, ард иргэдэд хүрэх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Байгаль орчны үнэлгээний уламжлалт аргууд нь учир дутагдалтай юм. Ногоон эдийн засгийн бодлогын зорилтуудад тэгш байдал болон оролцооны аргын ач холбогдлын талаар тусгасан бөгөөд бид бодлогын зорилтуудыг баяжуулахад анхаарах шаардлагатай.

Бүх нийтийн оролцооны зарчим нь нээлттэй, ил тод, нийгэд хүртээмжтэй байдаг боловч бодит байдалд хэрэгжүүлэхэд хэд хэдэн бэрхшээл тохиолддог. Хэдийгээр өнөөдөр бид эерэг үр дүнд хүрч байгаа ч үйл ажиллагаа, бодлого, хөтөлбөрийн гадна үлддэг нийгмийн бүлгүүд, тэр дундаа нутгийн уугуул иргэдийн боломж бололцоог сайжруулахад илүү их чармайлт гарган ажиллах шаардлагатай байна. Байгаль орчны доройтлыг бууруулахад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь ямар их ач холбогдолтой талаар бидний хийсэн судалгааны дүн нотолж байна.

Засгийн газар бодлого хөтөлбөрүүддээ олон нийтийн үзэл санааг хэдий чинээ тусгаж чадна тэр хирээр өөрчлөлт, шинэчлэл хийгдэх болно. Иргэний нийгмийг дэмжсэн нөхцөлд эмэгтэй, эрэгтэй хүмүүс орон нутаг, улс орон, олон улсын түвшинд тэгш оролцох бөгөөд хэвлэл мэдээллийн эрх чөлөө нь олон нийтийн үзэл санаа, оролцоог нэмэгдүүлэхэд маш чухал нөлөөтэй.

Санхүү, хөрөнгө оруулалт

Тогтвортой хөгжлийн талаарх хэлэлцүүлгийн нэг чухал сэдэв нь хэдий хэмжээний хөрөнгийг ямар үйл ажиллагаанд яаж зарцуулах асуудал байдаг. Тэгш байдлын зарчим нь их хэмжээний байгалийн нөөц баялгийг ядуу улс орнуудад илүүтэй хуваарилах, цэвэр ус, эрчим хүчний хангамжийг сайжруулах замаар тэгш байдлыг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүнээс гарах сөрөг үр нөлөөг сааруулахад чиглэдэг юм.

Санхүүгийн дүн шинжилгээнээс дараах үндсэн 4 санаа урган гарч ирж байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын хэрэгцээ маш их байгаа боловч цэрэг, арми зэрэг бусад салбарт зарцуулж буй хөрөнгө оруулалтын зардлын хэмжээнээс хэтрэхгүй байгаа. Бүх нийтийг орчин үеийн эрчим хүчний эх үүсвэрт холбоход жилд зарцуулж буй хөрөнгө оруулалтын зардлын дундаж хэмжээ нь нэг жилд малтмал түлшинд зарцуулж буй хөрөнгө оруулалтын зардалын наймны нэгээс бага хэмжээтэй байна.
- Санхүүгийн эх үүсвэрийг бий болгоход төсвийн (хандивын байгууллагуудаас олгож буй төсвөөр голчлон санхүүждэг) санхүүжилт чухал боловч хувийн хэвшлийн санхүүжилт чухал үүрэгтэй. Төрийн зүгээс хувийн хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, төрийн санхүүжилтийг нэмэгдүүлэх болон хөрөнгө оруулалтын үр өгөөжтэй байдлыг дэмжих, орон нутгийн чадавхийг сайжруулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.
- Мэдээ мэдээлэл хязгаарлагдмал байгаа тул байгаль орчны тогтвортой хөгжилд зарцуулж буй төрийн болон хувийн хэвшлийн зардалд хяналт тавихад хүндрэлтэй байна. Одоо байгаа тоо мэдээгээр зөвхөн албан ёсны хөгжлийн

туслалцааны хэмжээг харуулах боломжтой юм.

- Санхүүжилт нь нарийн түвэгтэй мөртлөө уялдаа холбоогүй, салангид байгаа тул үр өгөөж муу, хөрөнгө оруулалтын зардалд тавих хяналт сул байна. Парис болон Акрагийн уулзалтаар тохирсон тусламжийн үр дүнг сайжруулах зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагаанаас суралцах хэрэгтэй байна.

Хэдийгээр эрэлт хэрэгцээ, үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулалтын талаарх мэдээлэл иж бүрэн биш, цар хүрээ нь ойлгомжгүй байгаа ч өнөөгийн нөхцөл байдлыг маш тодорхой харуулж чадсан. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарлыг бууруулах, цэвэр усны хангамж болон эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулахад зарцуулагдах албан ёсны тусламжийн зардал болон нэмж хийх шаардлагатай хөрөнгө оруулалтын зардлын хооронд ихээхэн зөрүүтэй байна. (Зураг 8). Нүүрстөрөгч бага ялгаруулдаг эрчим хүчний эх үүсвэрт зарцуулж буй хөрөнгө нь хамгийн багаар тооцсон хөрөнгө оруулалтын дөнгөж 1,6 хувийг эзэлж байхад уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүнээс үүдэн гарах сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн хөрөнгө оруулалт ойролцоогоор хамгийн багаар тооцсон санхүүжилтийн 11 хувийг эзэлж байна. Цэвэр усны хангамж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулахад зарцуулж буй хөрөнгө харьцангуй бага байгаа бөгөөд албан ёсны хөгжлийн туслалцаагаар зарцуулж буй хөрөнгийн хэмжээ урьдчилан тооцоолсон төсвийн хэмжээнээс нэг их зөрөхгүй байна.

Санхүүгийн нэмэлт эх үүсвэрийг бий болгох: Валют арилжаанд татвар ногдуулах оновчтой шийдлийг бодлогод тусгаж, хэрэгжүүлэх нь

Илтгэлд дурьдагдсан байгаль орчны доройтол, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд шаардагдах санхүүгийн нэмэлт эх үүсвэрийг шинэлэг санаагаар шийдэх боломжтой юм. Тухайлбал, валют арилжаанд татвар ногдуулах шийдлийг ашиглаж болно. 1994 оны Хүний хөгжлийн илтгэлд энэ санааг ихээр дэмжиж, хэрэгжүүлэх боломжтой бодлогын нэг хувилбар гэж үзсэн юм. Саяхан олон улсад нүүрлэсэн санхүүгийн хямралын улмаас энэхүү хувилбарыг хэрэгжүүлэх санаа дахин сэргэж, ач холбогдол, цаг хугацааны хувьд тохиромжтой шийдэл болох тухай онцлон тэмдэглэж байна.

Өнөөгийн гадаад валют арилжаалах дэд бүтэц боловсронгуй, төвлөрсөн зохион байгуулалтанд орж, стандартад нийцэх болсон учраас валют арилжааны татварыг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт өөрчлөлт, шинэ санааг олох хэрэгтэй. Энэхүү санааг Санхүүгийн Шинэлэг Тогтолцооны Тэргүүлэх бүлэг болох Хятад, Франц, Герман, Япон, Их Британи тэргүүтэй нийт 63 орон хүлээн зөвшөөрч байгаа билээ. Уур амьсгалын

Шинэчилсэн судалгаанаас харахад удирдлагын зардлыг тооцохгүйгээр дээрх валют арилжаанд ногдуулах татварын хэмжээг хамгийн багаар буюу 0,005 хувиар тооцоход ойролцоогоор 40 тэрбум ам. долларын нэмэлт орлого олох боломжтой гэдэг нь харагдаж байна. Ийм хөрөнгө босгох боломж байхад олон улсын хэлэлцүүлгээр тодорхойлсон бусад арга хэлбэрүүдийг хэрэгжүүлэх шаардлагагүй.


өөрчлөлтийг бууруулах санхүүжилтийн чиглэлээр ажилладаг НҮБ-ын Удирдлага дээрх татвараас олох орлогын 25-50 хувийг хөгжиж буй орнуудын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүний сөрөг

үр дагаврыг бууруулах үйл ажиллагаанд зарцуулах саналыг дэвшүүлсэн юм.

ЗУРАГ 8

Олон улсын хөгжлийн туслалцаа хэрэгцээгээ үл гүйцэх байдал

Олон улсын хөгжлийн албан ёсны туслалцааны өнөөгийн ба ирээдүйн тооцоолол (ОУХТ)
Жилийн зардал (тэрбум ам.доллар)



Эх сурвалж: Олон Улсын Эрчим Хүчний Байгууллага, 2010 он, Дэлхийн Эрчим хүчний төлөв байдал, Парис: Эдийн Засгийн Хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, НҮБ Ус, 2010, Олон улсын эрүүл ахуйн байдал, үндны усны жилийн үнэлгээ, Эерэг үр дүнд хүрэх Зорилтот Нөөц Баялаг, Женев: ДЭМБ, НҮБ-ын Эдийн Засаг, Нийгмийн Хэрэг хариуцсан газар, 2010, Хөгжлийн ахиц, Эх дэлхийг хамгаалах, Нью Йорк: НҮБ-ын Эдийн Засаг, Нийгмийн асуудалд хариуцсан газрын Тусламжийн үйл ажиллагааны хөгжлийн мэдээллийн сан, CRS холбоо.

Бидний шинэчилсэн судалгаанаас харахад удирдлагын зардлыг тооцохгүйгээр валют арилжаанд ногдуулах дээрх татварын хэмжээг хамгийн багаар буюу 0,005%-иар тооцоход ойролцоогоор 40 тэрбум ам долларын нэмэлт орлого олох боломжтой гэдэг нь харагдаж байна. Ийм хөрөнгө үүсгэх боломж байхад олон улсын хэлэлцээрээр тодорхойлсон бусад арга хэлбэрийг хэрэгжүүлэх шаардлагагүй юм.

Валют арилжаанд татвар ногдуулахаас гадна илүү өргөн хэмжээний буюу санхүүгийн арилжааны татвараас мөн их хэмжээний ашиг олох боломжтой байна. G-20 улсын дийлэнх нь энэхүү татварын системийг ашиглаж эхэлсэн бөгөөд Олон Улсын Валютын Сангаас энэ татварын системийг хэрэгжих боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Санхүүгийн арилжааны татварын нэг хувилбар нь

дотоодын болон олон улсын санхүүгийн гүйлгээнд 0,05 хувийн татвар ногдуулах буюу энэ үйл ажиллагаанаас ойролцоогоор 600-700 тэрбум ам долларын орлого олох боломжтой.

ОУВС-ийн илүү гарсан хөрөнгийг эргэлтэнд оруулдаг SDRs (ОУВС-ийн байгуулсан гишүүн орнуудын валютыг нөөцлөх үйл ажиллагааны нэг хэлбэр) нь мөн анхаарал татаж буй санхүүгийн нэмэлт эх үүсвэр юм. Энэ аргыг ашигласнаар хамгийн багадаа 75 сая ам. долларын ашиг олох бөгөөд засгийн газрын зүгээс энэ үйл ажиллагаанд төсөв төлөвлөх шаардлагагүй. SDR нь валютын ханшийг эргэн тэнцвэржүүлэх арга хэлбэрийг өөртөө нэмж тусгасан бөгөөд нөөцийн нэр төрлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн шинэ зах зээлийн эдийн засгийн боломжуудаас түүнийг эрэлт хэрэгцээ нь урган гарч байгаа юм.

Эрх тэгш байдал болон бүх нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн шинэчлэлт

Бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид болон байгаль орчны доройтолд өртөмтгий, орлого багатай иргэдийн хоорондох заагийг арилгахын тулд олон улсын байгаль орчны засаглалын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх хэрэгтэй. Дан ганц үүрэг хариуцлагыг өндөржүүлснээр дээрх асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй боловч үүрэг хариуцлагыг нэмэгдүүлснээр бүх нийтэд хүртээмжтэй нийгмийн болон байгаль орчны олон улсын үр дүнтэй, зөв засаглал бүрэлдэн тогтох үндэс суурийг тавьж өгөх юм.

Бид байгаль орчны доройтлыг бууруулахад чиглэсэн санхүүгийн урсгалд тэгш байдал болон олон нийтийн дуу хоолойг нэмэгдүүлэх арга хэмжээ авах хэрэгтэй байна.

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт мөн нэн чухал юм. Гэвч хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдын үзэж буйгаар зарим бус нутагт эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт хийх нь эрсдэл ихтэй, үр ашиг багатай гэж үздэг тул санхүүгийн нийт урсгалд хувийн хэвшлийн эзлэх хувь нэмэр бага байдаг. Шинэчлэлт хийхгүй бол улс орнуудын эдийн засгийн тэгш бус байдал хэвээр үлдэж, улам газар авах талтай юм. Эндээс харахад Засгийн газрын хөрөнгө оруулалтуудыг жигд хүртээх, цаашид хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах таатай нөхцлийг бүрдүүлэх ач холбогдлыг онцлон дурьдсан юм.

Тэгш байдлын зарчмыг зөв удирдан хэрэгжүүлж, олон улсын санхүүгийн урсгалыг хөхиүлэн дэмжих хэрэгтэй. Хөгжиж буй орнуудад оновчтой бодлого хөтөлбөр боловсруулах институц байгуулахад дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна. Олон улсын төсвийн санхүүжилтийг зохицуулах механизм олон нийтийн дуу хоолойг сонсох, оролцоог нэмэгдүүлэх нийгмийн хариуцлагыг бий болгоход чиглэж байх ёстой.

Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах буюу зогсооход чиглэсэн аливаа хүчин чармайлт нь дотоодыг олон улстай, төрийг хувийн хэвшилтэй, буцалтгүй тусламжийг зээлийн тусламжтай хослуулан нэгтгэсэн байх шаардлагатай байна. Олон улсын санхүүгийн урсгалын тэгш хуваарилан, үр өгөөжтэй ашиглах явдлыг дэмжихийн тулд улсын түвшинд холбогдох байгууллага, талуудыг чадавхижуулах хэрэгтэй гэсэн зөвлөмжийг 2011 оны Дэлхийн Хүний Хөгжлийн Илтгэл гаргаж байна. Улс орнуудын түвшинд, үндэсний хэмжээнд уур амьсгалын асуудлыг хариуцсан сан байгуулах нь дээр дурьдсан хослуулах арга хэлбэрийг хэрэгжүүлэх явцыг дэмжиж, дотоодын болон олон улсын, хувийн хэвшлийн болон төрийн санхүүжилт, буцалтгүй тусламж болон зээлийн үйл ажиллагааг хянаж чадах юм. Энэ нь дотоодын хариуцлагыг өндөржүүлж, үйл ажиллагааг жигд хэрэгжүүлэхэд нэн тустай.

Энэхүү үйл ажиллагааг улам урагшлуулан хэрэгжүүлэхийн тулд улсын түвшинд авч үзэх дараах 4 арга хэрэгслийг тус илтгэл онцоллоо. Үүнд:

- Хүний хөгжил, эрх тэгш байдлыг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах зорилтуудыг хослуулан хэрэгжүүлэхийн тулд нүүрстөрөгчийн давхар ислийн ялгаралыг бууруулж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратегийг боловсруулах хэрэгтэй.
- Бизнесийн үйл ажиллагаа болон айл өрхөөс бий болох баялгийг нэмэгдүүлэхийн тулд төрийн болон хувийн хэвшлийн санхүүжилтийг хослуулах.
- Олон улсын төрийн санхүүжилтийг тэгш хүртээх үүднээс уур амьсгалын өөрчлөлтийг зохицуулахад зориулсан санхүүжилтийг бий болгох
- Урт хугацааны, үр өгөөж сайтай үр дүнд хүрч, орон нутгийн иргэд болон хамтрагч байгууллагуудын хариуцлагыг өндөржүүлэхийн тулд үйл ажиллагааны хэрэгжилтийг хяналт, тайлагнах системийг хооронд нь уялдуулах

Бүх нийтийг орчин үеийн эрчим хүчээр хангах санаачлагыг нийтэд сурталчилж, ухамсарлуулахын сацуу улсын түвшинд цэвэр эрчим хүчээр хангах үйл ажиллагааг дэмжих хэрэгтэй. Дээрх санаачлага нь багахан хэмжээний өөрчлөлтөөс богино хугацаанд томоохон өөрчлөлтөд хүрэхэд түлхэц болох юм.

* * *

Тус илтгэл тогтвортой хөгжил болон эрх тэгш байдлын хоорондын уялдаа холбооны эерэг талыг, мөн хүний хөгжлийг хэрхэн тогтвортой, эрх тэгш болгох талаар тусгалаа. Эндээс байгаль орчны доройтол нь эмзэг буурай хүн ам, нийгмийн бүлэгт ямар хүндээр тусдагийг харж болно. Тиймээс бид эдгээр тэнцвэргүй байдлыг бууруулах, өнөөгийн байгаль орчны тулгамдсан асуудлуудыг хүний хөгжил болон эрх тэгш байдалтай уялдуулан шийдвэрлэх стратеги боловсруулах талаар зөвлөмж гаргалаа. Зөвхөн зөвлөмж өгөөд зогсохгүй илтгэлд дурьдсанчлан хүний сонголтыг нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн зорилтуудыг биелүүлэх хэд хэдэн бодит аргыг танилцууллаа.

Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах буюу зогсооход чиглэсэн аливаа оролдлого нь дотоодыг олон улстай, төрийн хэвшлийн хувийн хэвшилтэй, буцалтгүй тусламжийг зээлийн тусламжтай хослуулан нэгтгэсэн байх шаардлагатай байна

2011 оны Хүний Хөгжлийн Индекс, 2010 оны үзүүлэлттэй харьцуулсан өөрчлөлт

Австрали	2	Итали	24	Самоа	99
Австри	19	Йемен	154	Сан Томе ба Принсипи	144 ↓ -1
Азербайжан	91	Кабо-Верде	133	Саудын Араб	56 ↑ 2
Албани	70 ↑ 1	Казахстан	68 ↑ 1	Свазиланд	140 ↓ -2
Алжир	96	Камбож	139 ↑ 2	Сейшелийн арлууд	52
Ангол	148	Камерун	150 ↑ 1	Сенегал	155
АНУ	4	Канад	6	Сент-Винсент ба Гренадин	85 ↓ -1
Андорра	32	Катар	37	Сент-Китс ба Невис	72
Антигуа ба Барбуда	60 ↑ 1	Кени	143 ↑ 1	Сент-Люсия	82
Арабын Нэгдсэн Эмирт Улс	30	Кипр	31	Серби	59 ↑ 1
Аргентин	45 ↑ 1	Кирибати	122	Сингапур	26
Армен	86	Колумб	87 ↑ 1	Сири	119 ↓ -1
Афганистан	172	Коморын арлууд	163	Словак	35
Багамын арлууд	53	Конго	137	Словени	21
Бангладеш	146	Конго /Ардчилсан Улс/	187	Солонгос /өмнөд/	15
Барбадос	47	Коста-Рика	69 -1	Соломоны арлууд	142
Балба	157 ↓ -1	Куба	51	Судан	169
Бахрейн	42	Кувейт	63 ↓ -1	Суринам	104
Беларусь	65	Кыргызстан	126	Сьера-Леоне	180
Белиз	93 ↓ -1	Лаос	138 ↑ 1	Тажикистан	127
Бельги	18	Латви	43	Тайланд	103
Бенин	167	Лесото	160	Танзани	152 ↑ 1
Болгар	55 ↑ 1	Либериа	182 ↑ 1	Того	162
Боливи	108	Ливан	71 ↓ -1	Тонга	90
Босни –Герцеговин	74	Ливи	64 ↓ -10	Тринидад ба Тобаго	62 ↑ 1
Ботсван	118 ↓ -1	Литва	40 ↑ 1	Тунис	94 ↓ -1
Бразил	84 ↑ 1	Лихтенштейн	8	Туркменистан	102
Бруней	33	Люксембург	25	Турк	92 ↑ 3
Буркина Фасо	181	Маврики	77	Төв Африкийн БН Улс	179
Бурунди	185	Мавритани	159 ↓ -1	Уганда	161
Вануату	125 ↓ -2	Мадагаскар	151 ↓ -2	Узбекистан	115
Венесуэл /Боливарын Улс/	73	Малави	171	Украйн	76 ↑ 3
Вьетнам	128	Малайз	61 ↑ 3	Унгар	38
Габон	106	Мали	175	Уругвай	48
Гайти	158 ↑ 1	Мальдив	109	Хонг Конг	13 ↑ 1
Гайана	117 ↑ 2	Мальта	36	Хорват	46 ↓ -1
Гамби	168	Марокко	130	Хятад	101
Гана	135 ↑ 1	Мексик	57	Фижи	100 ↓ -3
Гватемал	131	Микронези	116	Филиппин	112 ↑ 1
Гвиней	178	Мозамбик	184	Финлянд	22
Гвиней-Бисау	176	Молдав	111	Франц	20
Герман	9	Монгол Улс	110	Чад	183 ↓ -1
Гондурас	121 ↓ -1	Мьянмар	149 ↑ 1	Чех	27
Гренада	67	Намиби	120 ↑ 1	Чили	44
Грек	29	Нигер	186	Швейцари	11
Гүрж	75	Нигери	156 ↑ 1	Швед	10
Дани	16	Нидерланд	3	Шри-Ланка	97 ↑ 1
Джибути	165 ↓ -1	Никарагуа	129	Шинэ Зеланд	5
Доминик	81 ↓ -1	Норвеги	1	Эквадор	83
Доминиканы БН Улс	98 ↑ 2	Нэгдсэн Вант Улс	28	Экваторын Гвиней	136 ↓ -1
Египет	113 ↓ -1	Оман	89	Энэтхэг	134
Зааны ясан эрэг	170	ОХУ	66	Эритрей	177
Замби	164 ↑ 1	Өмнөд Африк	123 ↑ 1	Эстон	34
Зимбабве	173	Пакистан	145	Этиоп	174
Зүүн Тимор-Лесте	147	Палау	49	Ямайка	79 ↓ -1
Израиль	17	Панама	58 ↑ 1	Япон	12
Индонез	124 ↑ 1	Папуа – Шинэ Гвиней	153 ↓ -1		
Йордан	95 ↓ -1	Парагвай	107		
Ирак	132	Перу	80 ↑ 1		
Иран	88 ↓ -1	Польш	39		
Ирланд	7	Португал	41 ↓ -1		
Исланд	14 ↓ -1	Руанда	166		
Испани	23	Сальвадор	105		

Тайлбар:

2005–2011 он дарааллын мэдээлэл, өгөгдлийн сан болон аргачлалыг авч үзсэний дагуу тухайн улсын рейтинг дараалалд гарсан өөрчлөлтийг дээш, доош заасан сумаар илэрхийлсэн бөгөөд хоосон байгаа нь өөрчлөлт гараагүй болохыг илтгэнэ.

Хүний хөгжлийн индексийн үзүүлэлт

Улс орнуудын ХХИ-ийн дараалал	Хүний Хөгжлийн Индекс (ХХИ)	Тэгш бус байдлыг тооцсон ХХИ		Жендэрийн тэгш бус байдлын индекс		Ядуурлын олон хэмжүүрт индекс	
		Бодит утга	Дараалал	Бодит утга	Дараалал		
ХХИ-ийн маш өндөр үзүүлэлттэй орнууд							
1	Норвеги	0,943	0,890	1	0,075	6	..
2	Австрали	0,929	0,856	2	0,136	18	..
3	Нидерланд	0,910	0,846	4	0,052	2	..
4	АНУ	0,910	0,771	23	0,299	47	..
5	Шинэ Зеланд	0,908	0,195	32	..
6	Канад	0,908	0,829	12	0,140	20	..
7	Ирланд	0,908	0,843	6	0,203	33	..
8	Лихтенштейн	0,905
9	Герман	0,905	0,842	7	0,085	7	..
10	Швед	0,904	0,851	3	0,049	1	..
11	Швейцари	0,903	0,840	9	0,067	4	..
12	Япон	0,901	0,123	14	..
13	Хонг Конг	0,898
14	Исланд	0,898	0,845	5	0,099	9	..
15	Өмнөд Солонгос	0,897	0,749	28	0,111	11	..
16	Дани	0,895	0,842	8	0,060	3	..
17	Израйль	0,888	0,779	21	0,145	22	..
18	Бельги	0,886	0,819	15	0,114	12	..
19	Австри	0,885	0,820	14	0,131	16	..
20	Франц	0,884	0,804	16	0,106	10	..
21	Словени	0,884	0,837	10	0,175	28	0,000
22	Финлянд	0,882	0,833	11	0,075	5	..
23	Испани	0,878	0,799	17	0,117	13	..
24	Италия	0,874	0,779	22	0,124	15	..
25	Люксембург	0,867	0,799	18	0,169	26	..
26	Сингапур	0,866	0,086	8	..
27	Чех	0,865	0,821	13	0,136	17	0,010
28	Нэгдсэн Вант Улс	0,863	0,791	19	0,209	34	..
29	Грек	0,861	0,756	26	0,162	24	..
30	Арабын Нэгдсэн Эмирт Улс	0,846	0,234	38	0,002
31	Кипр	0,840	0,755	27	0,141	21	..
32	Андора	0,838
33	Бруней-Даруссалам	0,838
34	Эстони	0,835	0,769	24	0,194	30	0,026
35	Словак	0,834	0,787	20	0,194	31	0,000
36	Мальта	0,832	0,272	42	..
37	Катар	0,831	0,549	111	..
38	Унгар	0,816	0,759	25	0,237	39	0,016
39	Польш	0,813	0,734	29	0,164	25	..
40	Литва	0,810	0,730	30	0,192	29	..
41	Португал	0,809	0,726	31	0,140	19	..
42	Бахрейн	0,806	0,288	44	..
43	Латви	0,805	0,717	33	0,216	36	0,006
44	Чили	0,805	0,652	44	0,374	68	..
45	Аргентин	0,797	0,641	47	0,372	67	0,011
46	Хорват	0,796	0,675	38	0,170	27	0,016
47	Барбадос	0,793	0,364	65	..
ХХИ-ийн өндөр үзүүлэлттэй орнууд							
48	Уругвай	0,783	0,654	43	0,352	62	0,006
49	Палау	0,782
50	Румын	0,781	0,683	36	0,333	55	..
51	Куба	0,776	0,337	58	..

Улс орнуудын ХХИ-ийн дараалал		Хүний Хөгжлийн Индекс (ХХИ)		Тэгш бус байдлыг тооцсон ХХИ		Жендэрийн тэгш бус байдлын индекс		Ядуурлын олон хэмжүүрт индекс
		Бодит утга	Бодит утга	Дараалал	Бодит утга	Дараалал		
53	Багамын арлууд	0,771	0,658	41	0,332	54	..	
54	Черногория	0,771	0,718	32	0,006	
55	Болгар	0,771	0,683	37	0,245	40	..	
56	Саудын Араб	0,770	0,646	135	..	
57	Мексик	0,770	0,589	56	0,448	79	0,015	
58	Панама	0,768	0,579	57	0,492	95	..	
59	Серби	0,766	0,694	34	0,003	
60	Антигуа ба Барбуда	0,764	
61	Малайз	0,761	0,286	43	..	
62	Тринидад и Тобаго	0,760	0,644	46	0,331	53	0,020	
63	Кувейт	0,760	0,229	37	..	
64	Ливи	0,760	0,314	51	..	
65	Беларусь	0,756	0,693	35	0,000	
66	Оросын Холбооны Улс	0,755	0,670	39	0,338	59	0,005	
67	Гренада	0,748	
68	Казахстан	0,745	0,656	42	0,334	56	0,002	
69	Коста-Рика	0,744	0,591	55	0,361	64	..	
70	Албани	0,739	0,637	49	0,271	41	0,005	
71	Ливан	0,739	0,570	59	0,440	76	..	
72	Сент-Китс ба Невис	0,735	
73	Венесуэл (Боливарын Улс)	0,735	0,540	67	0,447	78	..	
74	Босни-Герцеговин	0,733	0,649	45	0,003	
75	Гүрж	0,733	0,630	51	0,418	73	0,003	
76	Украин	0,729	0,662	40	0,335	57	0,008	
77	Маврикий	0,728	0,631	50	0,353	63	..	
78	Македон	0,728	0,609	54	0,151	23	0,008	
79	Ямайка	0,727	0,610	53	0,450	81	..	
80	Перу	0,725	0,557	63	0,415	72	0,086	
81	Доминика	0,724	
82	Сент-Люсия	0,723	
83	Эквадор	0,720	0,535	69	0,469	85	0,009	
84	Бразил	0,718	0,519	73	0,449	80	0,011	
85	Сен-Винсент ба Гренадин	0,717	
86	Армен	0,716	0,639	48	0,343	60	0,004	
87	Колумб	0,710	0,479	86	0,482	91	0,022	
88	Иран	0,707	0,485	92	..	
89	Оман	0,705	0,309	49	..	
90	Тонга	0,704	
91	Азербайжан	0,700	0,620	52	0,314	50	0,021	
92	Турк	0,699	0,542	66	0,443	77	0,028	
93	Белиз	0,699	0,493	97	0,024	
94	Тунис	0,698	0,523	72	0,293	45	0,010	
ХХИ-ийн дундаж үзүүлэлттэй орнууд								
95	Иордания	0,698	0,565	61	0,456	83	0,008	
96	Алжир	0,698	0,412	71	..	
97	Шри-Ланка	0,691	0,579	58	0,419	74	0,021	
98	Доминиканы БНУ	0,689	0,510	77	0,480	90	0,018	
99	Самоа	0,688	
100	Фижи	0,688	
101	Хятад	0,687	0,534	70	0,209	35	0,056	
102	Туркменистан	0,686	
103	Тайланд	0,682	0,537	68	0,382	69	0,006	
104	Суринам	0,680	0,518	74	0,039	
105	Сальвадор	0,674	0,495	83	0,487	93	..	
106	Габон	0,674	0,543	65	0,509	103	0,161	
107	Парагвай	0,665	0,505	78	0,476	87	0,064	
108	Боливи	0,663	0,437	87	0,476	88	0,089	

Улс орнуудын ХХИ-ийн дараалал	Хүний Хөгжлийн Индекс (ХХИ)			Тэгш бус байдлыг тооцсон ХХИ		Жендэрийн тэгш бус байдлын индекс		Ядуурлын олон хэмжүүрт индекс
	Бодит утга	Бодит утга	Дараалал	Бодит утга	Дараалал	Бодит утга	Дараалал	
110 Монгол	0,653	0,563	62	0,410	70	0,065		
111 Молдав	0,649	0,569	60	0,298	46	0,007		
112 Филиппин	0,644	0,516	75	0,427	75	0,064		
113 Египет	0,644	0,489	85	0,024		
114 Палестины нутаг дэвсгэрүүд	0,641	0,005		
115 Узбекистан	0,641	0,544	64	0,008		
116 Микронези	0,636	0,390	94		
117 Гайана	0,633	0,492	84	0,511	106	0,053		
118 Ботсван	0,633	0,507	102	..		
119 Сири	0,632	0,503	80	0,474	86	0,021		
120 Намиби	0,625	0,353	99	0,466	84	0,187		
121 Гондурас	0,625	0,427	89	0,511	105	0,159		
122 Кирибати	0,624		
123 Өмнөд Африк	0,619	0,490	94	0,022		
124 Индонез	0,617	0,504	79	0,505	100	0,095		
125 Вануату	0,617	0,129		
126 Кыргызстан	0,615	0,526	71	0,370	66	0,019		
127 Тажикистан	0,607	0,500	81	0,347	61	0,068		
128 Вьетнам	0,593	0,510	76	0,305	48	0,084		
129 Никарагуа	0,589	0,427	88	0,506	101	0,128		
130 Марокко	0,582	0,409	90	0,510	104	0,048		
131 Гватемал	0,574	0,393	92	0,542	109	0,127		
132 Ирак	0,573	0,579	117	0,059		
133 Кабо-Верде	0,568		
134 Энэтхэг	0,547	0,392	93	0,617	129	0,283		
135 Гана	0,541	0,367	96	0,598	122	0,144		
136 Экваторын Гвиней	0,537		
137 Конго	0,533	0,367	97	0,628	132	0,208		
138 Лаос	0,524	0,405	91	0,513	107	0,267		
139 Камбож	0,523	0,380	95	0,500	99	0,251		
140 Свазиланд	0,522	0,338	103	0,546	110	0,184		
141 Бутан	0,522	0,495	98	0,119		
ХХИ-ийн доогуур үзүүлэлттэй орнууд								
142 Соломоны Арлууд	0,510		
143 Кени	0,509	0,338	102	0,627	130	0,229		
144 Сан-Томе ба Принсипи	0,509	0,348	100	0,154		
145 Пакистан	0,504	0,346	101	0,573	115	0,264		
146 Бангладеш	0,500	0,363	98	0,550	112	0,292		
147 Зүүн Тимор	0,495	0,332	105	0,360		
148 Ангол	0,486	0,452		
149 Мьянмар	0,483	0,492	96	0,154		
150 Камерун	0,482	0,321	107	0,639	134	0,287		
151 Мадагаскар	0,480	0,332	104	0,357		
152 Танзан	0,466	0,332	106	0,590	119	0,367		
153 Папуа – Шинэ Гвиней	0,466	0,674	140	..		
154 Йемен	0,462	0,312	108	0,769	146	0,283		
155 Сенегал	0,459	0,304	109	0,566	114	0,384		
156 Нигер	0,459	0,278	116	0,310		
157 Балба	0,458	0,301	111	0,558	113	0,350		
158 Гаити	0,454	0,271	121	0,599	123	0,299		
159 Мавритани	0,453	0,298	112	0,605	126	0,352		
160 Лесото	0,450	0,288	115	0,532	108	0,156		
161 Уганда	0,446	0,296	113	0,577	116	0,367		
162 Того	0,435	0,289	114	0,602	124	0,284		
163 Коморын арлууд	0,433	0,408		
164 Замби	0,430	0,303	110	0,627	131	0,328		
165 Джибути	0,430	0,275	118	0,139		

Улс орнуудын ХХИ-ийн дараалал	Хүний Хөгжлийн Индекс (ХХИ)	Тэгш бус байдлыг тооцсон ХХИ		Жендэрийн тэгш бус байдлын индекс		Ядуурлын олон хэмжүүрт индекс	
		Бодит утга	Бодит утга	Дараалал	Бодит утга		Дараалал
167	Бенин	0,427	0,274	119	0,634	133	0,412
168	Гамби	0,420	0,610	127	0,324
169	Судан	0,408	0,611	128	..
170	Зааны Ясан Эрэг	0,655	0,353	136	0,400	124	0,246
171	Малави	0,400	0,272	120	0,594	120	0,381
172	Афганистан	0,398	0,707	141	..
173	Зимбабве	0,376	0,268	122	0,583	118	0,180
174	Этиоп	0,363	0,247	123	0,562
175	Мали	0,359	0,712	143	0,558
176	Гвиней-Бисау	0,353	0,207	129
177	Эритрей	0,349
178	Гвиней	0,344	0,211	128	0,506
179	Төв Африкийн БН Улс	0,343	0,204	130	0,669	138	0,512
180	Сьерра-Леоне	0,336	0,196	131	0,662	137	0,439
181	Буркина-Фасо	0,331	0,215	126	0,596	121	0,536
182	Либериа	0,329	0,213	127	0,671	139	0,485
183	Чад	0,328	0,196	132	0,735	145	0,344
184	Мозамбик	0,322	0,229	125	0,602	125	0,512
185	Бурунди	0,316	0,478	89	0,530
186	Нигер	0,295	0,195	133	0,724	144	0,642
187	Конго /Ардчилсан/	0,286	0,172	134	0,710	142	0,393
БУСАД УЛС ОРОН, ГАЗАР НУТАГ							
	Солонгос, Хойд
	Маршаллын арлууд
	Монако
	Науру
	Сан-Марино
	Сомали	0,514
	Тувалу
ХХИ-ИЙН БҮЛЭГ							
	Маш өндөр ХХИ	0,889	0,787	—	0,224	—	—
	Өндөр ХХИ	0,741	0,590	—	0,409	—	—
	Дунд ХХИ	0,630	0,480	—	0,475	—	—
	Доогуур үзүүлэлт ХХИ	0,456	0,304	—	0,606	—	—
БҮС НУТГУУД							
	Арабын орнууд	0,641	0,472	—	0,563	—	—
	Зүүн Ази ба Номхон далайн бүс нутаг	0,671	0,528	—	..	—	—
	Европ болон Төв Ази	0,751	0,655	—	0,311	—	—
	Латин Америк болон Карибын сав нутаг	0,731	0,540	—	0,445	—	—
	Өмнөд Ази	0,548	0,393	—	0,601	—	—
	Сахарын Африк	0,463	0,303	—	0,610	—	—
	Нэн буурай хөгжилтэй орнууд	0,439	0,296	—	0,594	—	—
	Жижиг арлын хөгжиж буй орнууд	0,640	0,458	—	..	—	—
	Дэлхийн дундаж	0,682	0,525	—	0,492	—	—